

Тунхаглалын эцсийн хувилбар
2018 оны 10 дугаар сар

УСНББОУС™

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт™

2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд

IPSASB

Улсын Секторын Нягтлан
Бодох Бүртгэлийн Олон
Улсын Стандартын Зөвлөл™



Улсын Секторын Нягтлан
Бодох Бүртгэлийн Олон
Улсын Стандартын Зөвлөл™

Энэхүү баримт бичгийг Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (УСНББОУСЗ™) боловсруулж, баталсан.

УСНББОУСЗ-ийн зорилго нь улсын секторын нягтлан бодох бүртгэлийн өндөр чанартай стандартуудыг тогтоох, тэдгээрийн мөрдөлт ба хэрэгжүүлэлтэнд туслалцаа үзүүлэх, ингэснээр дэлхий дахины практикын чанар ба тууштай байдлыг сайжруулах, улсын секторын санхүүгийн ил тод, хариуцлагатай байдлыг бэхжүүлэх замаар олон нийтийн эрх ашигт үйлчлэх явдал юм.

Энэхүү зорилтыг биелүүлэхийн тулд УСНББОУСЗ нь улсын секторын байгууллагууд, үүн дотроо үндэсний, бүсийн, орон нутгийн засгийн газрууд болон засгийн газрын холбогдох агентлагууд ашиглахад зориулсан Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд™ (УСНББОУС-ууд™) ба Санал Болгосон Практик Удирдамж (СБПУ)-уудыг гаргадаг.

УСНББОУС нь нийтлэг зорилготой санхүүгийн тайлан (санхүүгийн тайлан)-д хамааралтай бөгөөд бүрэн эрхтэй байдаг. СБПУ-ууд нь санхүүгийн тайланг биш, харин нийтлэг зориулалттай санхүүгийн тайлан илтгэл (НЗСТИ)-ийг бэлтгэх сайн практикын талаархи заавар удирдамжаар хангадаг тунхаглалууд юм. УСНББОУС-аас ялгаатай нь, СБПУ нь шаардлагуудыг тогтоодоггүй. Санхүүгийн тайлан биш, харин НЗСТИ-тэй холбоотой бүх тунхаглалууд нь одоогоор СБПУ-ууд байна. СБПУ-ууд нь мэдээлэлд хамаарах баталгааны (хэрэв байгаа бол) түвшний талаархи заавар удирдамжаар хангадаггүй.

УСНББОУСЗ-ийн үйл ажиллагаагаа явуулах бүтэц болон үйл явцад Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо™ (ДНБХ™) дэмжлэг үзүүлдэг.

Зохиогчийн эрх © 2018 оны 10 дугаар сар, Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ). Зохиогчийн эрх, худалдааны тэмдэг, зөвшөөрлийн талаархи мэдээллийг [48-р хуудаснаас](#) үзнэ үү.

2018 ОНЫ УСНББОУС-ЫН САЙЖРУУЛАЛТУУД

АГУУЛГА

	Параграф
Хэсэг I: УСНББОУС-ын Ерөнхий Сайжруулалтууд	4
Хэсэг II: СТОУС-тай нийцүүлэх нэмэлт өөрчлөлтүүд	22

ХЭСЭГ I: УСНББОУС-ЫН ЕРӨНХИЙ САЙЖРУУЛАЛТУУД**Зорилго**

1. 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын Хэсэг I-ийн зорилго нь оролцогч талуудын дэвшүүлсэн асуудлуудыг авч үзэхийн тулд УСНББОУС-д сайжруулалт хийх явдал юм.

Харгалзан үзсэн УСНББОУС

2. 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд нь хоорондоо хамааралгүй нэмэлт өөрчлөлтүүдийн цуглуулга байдлаар УСНББОУС-д хийсэн материаллаг бус өөрчлөлтүүдийг авч үзсэн. Хэсэг I-д тусгасан нэмэлт өөрчлөлтүүд нь оролцогч талуудаас хүлээн авсан санал шүүмжлэлд үндэслэсэн.

УСНББОУС-ын Сайжруулалтууд

Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС	Өөрчлөлтийн товч тойм
Хэсэг I-1a Хэсэг I-1б Хэсэг I-1в	УСНББОУС 10, <i>Хэт Инфляцитай Эдийн Засгийн Үеийн Санхүүгийн Тайлагнал</i> УСНББОУС 22, <i>Засгийн Газрын Үндсэн Секторын Талаархи Санхүүгийн Мэдээллийн Тодруулга</i> УСНББОУС 24, <i>Санхүүгийн Тайлан дахь Төсвийн Мэдээллийн Толлуулга</i>	Тухайн Стандартын хүрээнд болон бүх УСНББОУС-ын хоорондох тууштай байдлыг хангахын тулд “анхдагч санхүүгийн тайлан” нэр томъёог (УСНББОУС-д тодорхойлоогүй) “санхүүгийн тайлан” нэр томъёогоор (тодорхойлсон нэр томъёо) сольж орлуулсан.
Хэсэг I-2	УСНББОУС 16, <i>Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө</i>	Байгууллага нь бодит үнэ цэнээр бүртгэх, өөрийн барьж байгуулж буй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн барилгын ажил буюу хөгжүүлэлтийг хийж дуусгасан үед хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх шаардлагуудыг шинэчлэн өөрчилсөн. 2010 оны 01-р сард гаргасан, <i>УСНББОУС-ын Сайжруулалтууд</i> -аар хийгдсэн нэмэлт өөрчлөлтийн дараа, барьж байгуулж буй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө нь УСНББОУС 16-гийн цар хүрээнд хамаардаг болсон, иймээс барилгын ажил дуусах үед хөрөнгийн өөр ангиас шилжүүлэлт хийгдэхгүй юм. 76-р параграф нь өөрийн барьж байгуулж буй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг бодит үнэ цэнээр анх хэмжих талаархи заавар удирдамжаар хангадаг гэдгийг тодорхой ойлгомжтой болгохын тулд уг параграфын өмнө шинэ гарчиг нэмж тусгасан. Барилгын ажил дуусахаас өмнө, бодит үнэ цэнээр хэмжиж болно гэдгийг тодруулж өгөх үүднээс 76-р параграфт мөн нэмэлт өөрчлөлт оруулсан.
Хэсэг I-3a Хэсэг I-3б	УСНББОУС 16, <i>Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө</i> УСНББОУС 17, <i>Үндсэн Хөрөнгө</i>	УСНББОУС 33, <i>Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх</i> -аар хийгдсэн бусад нэмэлт өөрчлөлтүүдтэй нийцүүлэхийн тулд шилжилтийн үеийн тодруулгын шаардлагуудад нэмэлт өөрчлөлт оруулсан.
Хэсэг I-4	УСНББОУС 31, <i>Биет Бус Хөрөнгө</i>	<i>Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт</i> (УСНББОУС 21, <i>Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт</i> болон УСНББОУС 26, <i>Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт</i> -ын Нэмэлт өөрчлөлтүүд) хэвлэгдсэний дараа, дахин үнэлсэн биет бус хөрөнгийг тусгах үүднээс биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа тодорхойгүй байсныг

2018 ОНЫ УСНББОУС-ЫН САЙЖРУУЛАЛТУУД

		тодорхой хугацаатай болгож дахин үнэлэх нь тухайн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэдгийг илэрхийлэх үзүүлэлт байх.
Хэсэг I-5	УСНББОУС 33, <i>Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх</i>	Зэрэгцүүлэгдэх мэдээллээр хангахаас чөлөөлөх заалт нь аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөний дараа гаргасан, зөвхөн анхны санхүүгийн тайланд мөрдөгдөнө гэдгийг тодруулах.
Хэсэг I-6	УСНББОУС 33, <i>Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх</i>	Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийн талаархи туршлагын залруулгыг тодруулах шаардлагаас чөлөөлөх хэрэггүй гэдгийг тусган илэрхийлэхийн тулд Дүгнэлтийн Үндэслэл болон Хэрэгжүүлэх Заавар Удирдамжийг шинэчлэн өөрчлөх. Ийм тодруулгыг өмнө нь УСНББОУС 25, <i>Ажилтны Тэтгэмж</i> -ээр шаарддаг байсан боловч уг Стандартын орлуулалт болох УСНББОУС 39, <i>Ажилтны Тэтгэмж</i> -д тухайн заалтыг оруулаагүй.
Хэсэг I-7	УСНББОУС 34, <i>Тусдаа Санхүүгийн Тайлан</i>	Өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш, хяналт тавигч байгууллагын тусдаа санхүүгийн тайлан дахь хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагуудын хэмжилт ба толилуулгыг засварлах нэмэлт өөрчлөлт.

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг I-1а

УСНББОУС 10, *Хэт Инфляцитай Эдийн Засгийн Үеийн Санхүүгийн Тайлагнал*-д оруулсан нэмэлт өөрчлөлт

1А ба 9-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 38Е параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Цар хүрээ

1А. **Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийн дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулдаг байгууллага нь анхдагч санхүүгийн тайландаа, түүнчлэн бүртгэлийн валют нь хэт инфляцитай эдийн засгийн үеийн валют байх аливаа байгууллагын нэгтгэсэн санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө.**

...

9. Хэт инфляцитай эдийн засгийн үед санхүүгийн тайланг тухайн тайлант үеийн эцэст үйлчилж буй хэмжилтийн нэгжээр илэрхийлсэн зөвхөн тийм тохиолдолд уг санхүүгийн тайлан нь ач холбогдолтой байна. Иймээс хэт инфляцитай эдийн засгийн үеийн валютаар тайлагнаж буй байгууллагуудын анхдагч санхүүгийн тайланд энэ Стандартыг мөрдөнө. Энэ Стандартаар шаардсан мэдээллийг тухайн дахин илэрхийлээгүй санхүүгийн тайланд нэмэлт гүйцээлт болгон толилуулахыг зөвшөөрөхгүй. Мөн түүнчлэн, дахин илэрхийлэлтээс өмнөх уг санхүүгийн тайланг тусдаа толилуулахыг дэмжихгүй.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

38Е. 2018 оны 10 дугаар сард гаргасан, 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 1А ба 9-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.

...

Дүгнэлтийн Үндэслэл

...

2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 10-д хийсэн хянан засварлалт

ДҮЗ. 1А ба 9-р параграфт “анхдагч санхүүгийн тайлан” гэж дурдсан. Энэхүү нэр томъёог УСНББОУС-д тодорхойлоогүй, иймээс будлиан үүсгэж болох юм гэдэгт санаа зовж буйгаа оролцогч талууд илэрхийлсэн. “Санхүүгийн тайлан” нэр томъёог УСНББОУС-ын аль ч хэсэгт ижил утгатайгаар ашигладаг гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Үүнтэй адилаар, УСНББОУС 10, *Хэт Инфляцитай Эдийн Засгийн Үеийн Санхүүгийн Тайлагнал* нь өөрийн адилтгах хүчин төгөлдөр параграфуудад “анхдагч санхүүгийн тайлан” биш, харин “санхүүгийн тайлан” нэр томъёог ашигладаг. Иймээс УСНББОУСЗ нь нэр томъёог стандартчилах ба “анхдагч санхүүгийн тайлан” нэр томъёог ашигласан аливаа тохиолдолд түүнийг “санхүүгийн тайлан” нэр томъёогоор орлуулахыг зөвшөөрсөн.

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг I-16

УСНББОУС 22, Засгийн Газрын Үндсэн Секторын Талаархи Санхүүгийн Мэдээллийн Тодруулга-д оруулсан нэмэлт өөрчлөлт

37-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 47Д параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Тодруулга

37. Энэ Стандарт нь санхүүгийн тайланд тусгасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардал, мөнгөн гүйлгээний гол ангиудыг тодруулахыг шаарддаг. ЗГҮС-ын тодруулгыг хийх арга маягийг энэ Стандартад тусгайлан заагаагүй. Энэ Стандартын дагуу ЗГҮС-ыг тодруулахаар сонголт хийсэн засгийн газар нь ийм тодруулгыг дараах арга замаар хийж болно. Үүнд: (а) тодруулга тэмдэглэлээр, (б) ~~анхдагч~~ санхүүгийн тайланд нэмэлт багана оруулах байдлаар, эсвэл (в) тухайн улс орны хувьд тохиромжтой гэж үзсэн бусад хэлбэрээр. Гэвч ЗГҮС-ын тодруулгыг толилуулах арга маяг нь УСНББОУС-уудын дагуу бэлтгэсэн, нэгтгэсэн санхүүгийн тайлангаас илүү давуутай байхгүй.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

47Д. 2018 оны 10 дугаар сард гаргасан, 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 37-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.

...

Дүгнэлтийн Үндэслэл

...

2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 22-д хийсэн хянан засварлалт

ДҮ16. 37-р параграфт “анхдагч санхүүгийн тайлан” гэж дурдсан. Энэхүү нэр томъёог УСНББОУС-д тодорхойлоогүй, иймээс будлиан үүсгэж болох юм гэдэгт санаа зовж буйгаа оролцогч талууд илэрхийлсэн. “Санхүүгийн тайлан” нэр томъёог УСНББОУС-ын аль ч хэсэгт ижил утгатайгаар ашигладаг гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Иймээс УСНББОУСЗ нь нэр томъёог стандартчилах ба “анхдагч санхүүгийн тайлан” нэр томъёог ашигласан аливаа тохиолдолд түүнийг “санхүүгийн тайлан” нэр томъёогоор орлуулахыг зөвшөөрсөн.

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг I-1в

УСНББОУС 24, Санхүүгийн Тайлан дахь Төсвийн Мэдээллийн Толилуулга-д оруулсан нэмэлт өөрчлөлт

21, 22, 24-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 54Г параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Төсөв ба гүйцэтгэлийн дүнгүүдийн зэрэгцүүлсэн толилуулга

...

Толилуулга ба тодруулга

21. Санхүүгийн тайлан ба төсвийг зөвхөн зэрэгцүүлэгдэх сууриар бэлтгэдэг тохиолдолд байгууллага нь төсвийн дүн болон гүйцэтгэлийн дүн хоорондох зэрэгцүүлэлтийг уг анхдагч санхүүгийн тайланд төсвийн нэмэлт багана оруулах байдлаар толилуулна.

22. Төсвийн болон гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох зэрэгцүүлэлтийг УСНББОУС 1-д тусгайлан заасанчлан, иж бүрэн санхүүгийн тайланд хамаарах тусдаа санхүүгийн тайлан (Төсөв ба Гүйцэтгэлийн Дүнгүүдийн Зэрэгцүүлэлтийн Тайлан буюу үүнтэй адилтгах нэршил бүхий тайлан)-д толилуулж болно. Өөр нэг хувилбар бол, санхүүгийн тайлан болон төсвийг зэрэгцүүлэгдэх сууриар, өөрөөр хэлбэл тухайн нэг байгууллагын хувьд ижил тайлант үед нэг ижил нягтлан бодох бүртгэлийн сууриар бэлтгэдэг бөгөөд нэг ижил ангиллын бүтцийг мөрддөг тохиолдолд УСНББОУС-ын дагуу толилуулсан одоо байгаа анхдагч санхүүгийн тайланд нэмэлт багана оруулж болох юм. Анхны ба тодотгосон төсвийн дүн, түүнчлэн тухайн байгууллага хүсвэл уг төсвийн болон гүйцэтгэлийн дүнгүүдийн хоорондох зөрүүг эдгээр нэмэлт багананд тусган харуулдаг.

...

24. Төсвийг аккруэл сууриар бэлтгэдэг бөгөөд иж бүрэн цогц санхүүгийн тайланг бэлтгэдэг улс орнуудын хувьд, УСНББОУС-аар шаардсан бүх анхдагч санхүүгийн тайланд төсвийн нэмэлт багануудыг оруулж болно. Харин өөр зарим улс орнуудын хувьд, УСНББОУС-д тусгайлан заасан, иж бүрэн цогц санхүүгийн тайлангийн зөвхөн зарим анхдагч санхүүгийн тайлан хэлбэрээр уг аккруэл сууриар бэлтгэсэн төсвийг толилуулж болно. Жишээлбэл; төсвийг санхүүгийн үр дүнгийн тайлан эсвэл мөнгөн гүйлгээний тайлан байдлаар толилуулах бөгөөд нэмэлт мэдээллийг дэмжих хүснэгтэнд харуулж болох юм. Ийм тохиолдолд, төсвийн толилуулгад бас хэрэглэсэн уг анхдагч санхүүгийн тайланд төсвийн нэмэлт багануудыг оруулж болно.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

54Г. 2018 оны 10 дугаар сард гаргасан, 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 21, 22, 24-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.

...

Дүгнэлтийн Үндэслэл

...

2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 24-д хийсэн хянан засварлалт

ДҮ24. 21, 22, 24-р параграфт “анхдагч санхүүгийн тайлан” гэж дурдсан. Энэхүү нэр томъёог УСНББОУС-д тодорхойлоогүй, иймээс будлиан үүсгэж болох юм гэдэгт санаа зовж буйгаа оролцогч талууд илэрхийлсэн. “Санхүүгийн тайлан” нэр томъёог УСНББОУС-ын аль ч хэсэгт ижил утгатайгаар ашигладаг гэдгийг УСНББОУСЗ тэмдэглэсэн. Иймээс УСНББОУСЗ нь нэр томъёог стандартчилах ба “анхдагч санхүүгийн тайлан” нэр томъёог ашигласан аливаа тохиолдолд түүнийг “санхүүгийн тайлан” нэр томъёогоор орлуулахыг зөвшөөрсөн.

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг I-2

УСНББОУС 16, Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө-д оруулсан нэмэлт өөрчлөлт

76-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 101Е параграфыг шинээр нэмсэн. 76-р параграфын өмнө шинэ гарчиг оруулсан. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Өөрөө барьж байгуулсан хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг бодит үнэ цэнээр анх хэмжих талаархи заавар удирдамж

76. Бодит үнэ цэнээр бүртгэх, өөрөө барьж байгуулсан хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн барилгын ажил буюу хөгжүүлэлт дууссан үед эсвэл түүний бодит үнэ цэнийг найдвартай хэмжих боломжтой үед (аль түүнд болсон өдрөөр) байгууллага нь уг өдрөөрх тухайн үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэ ба түүний өмнөх дансны үнийн хоорондох аливаа зөрүүг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

101Е. 2018 оны 10 дугаар сард гаргасан, 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 76, 97-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.¹

...

Дүгнэлтийн Үндэслэл

...

2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 16-д хийсэн хянан засварлалт

ДҮ9. Байгууллага нь өөрийн барилгын ажил буюу хөгжүүлэлтийг дуусгамагц хөрөнгийн өөр ангиллаас шилжүүлэлтийг хийж, үүний дараа бодит үнэ цэнээр бүртгэх, өөрөө барьж байгуулсан хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн хэмжилтийн талаархи шаардлагуудыг 76-р параграфт тусгасан байдаг. 2010 оны 01 дүгээр сард гаргасан, УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар хийгдсэн нэмэлт өөрчлөлтүүдийн үр дүнд, одоо барьж байгуулж буй хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө нь УСНББОУС 16-гийн цар хүрээнд хамаардаг болсон бөгөөд бодит үнэ цэнийн хэмжилтийг барилгын ажлын явцад эхлүүлж болох юм. Иймээс УСНББОУСЗ нь 76-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн.

¹ Энэ параграф нь доорх Нэмэлт өөрчлөлт: Хэсэг I-3а-гийн хүчин төгөлдөр болох хугацааг агуулсан болно.

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг I-3а

УСНББОУС 16, Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө-д оруулсан нэмэлт өөрчлөлт

97-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 101Ж параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Шилжилтийн нөхцөл

...

Бодит үнэ цэнийн загвар

...

97. (а) УСНББОУС 16-г (2001 он) өмнө нь мөрдөж байсан, ба (б) үйл ажиллагааны түрээсийн дагуу эзэмшиж буй, зохих шалгуур хангасан зарим буюу бүх үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоогоо анх удаа хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж ангилж, тайлагнах сонголт хийсэн байгууллага нь тэрхүү сонголтыг анх хийсэн тайлант үеийн хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдлийн залруулга байдлаар уг сонголтын үр нөлөөг хүлээн зөвшөөрнө. Түүнчлэн, ~~хэрэв байгууллага нь өмнөх тайлант үеүд дэж тэдгээр үл хөдлөх хөрөнгийн хувь оролцооны бодит үнэ цэнийг өмнө нь олон нийтэд (санхүүгийн тайландаа эсвэл өөр бусад байдлаар) толилуулж байсан бол 94(а) параграфыг мөрдөнө. Хэрэв байгууллага нь 94(а) параграфт дурдсан, тэдгээр үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоотой холбоотой мэдээллийг өмнө нь олон нийтэд толилуулж байгаагүй бол 94(б) параграфыг мөрдөнө.~~

(а) Хэрэв байгууллага нь өөрийн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн (бодит үнэ цэнийн тодорхойлолт болон 45-61-р параграф дахь заавар удирдамжийг хангах сууриар тодорхойлсон) бодит үнэ цэнийг өмнөх тайлант үеүдэд олон нийтэд (санхүүгийн тайландаа эсвэл өөр бусад байдлаар) өмнө нь толилуулж байсан бол тухайн байгууллага нь дараах зүйлсийг гүйцэтгэхийг сайшаан дэмжих боловч заавал шаардахгүй:

(i) Ийм бодит үнэ цэнийг тодруулсан хамгийн эхний тайлант үед толилуулсан, хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдлийг залруулах; ба

(ii) Тэдгээр тайлант үеүдийн зэрэгцүүлэгдэх мэдээллийг дахин илэрхийлэх;

(б) Хэрэв байгууллага нь дээрх (а) параграфт дурдсан, мэдээллийг өмнө нь олон нийтэд толилуулж байгаагүй бол зэрэгцүүлэгдэх мэдээллийг дахин илэрхийлэхгүй бөгөөд энэ тухай тодруулга хийнэ.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

[Дээрх Нэмэлт өөрчлөлт: Хэсэг I-2-т тусгасан, 101Е параграфыг үзнэ үү.]

...

Дүгнэлтийн Үндэслэл

...

2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 16-д хийсэн хянан засварлалт

ДҮ10. Үйл ажиллагааны түрээсийн дагуу эзэмшиж буй, зохих шалгуур хангасан зарим буюу бүх үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоогоо анх удаа хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж ангилж, тайлагнах сонголт хийсэн байгууллагуудад зориулсан шилжилтийн нөхцлүүдийг 97-р параграфт тусгасан байдаг. УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх-ийг гаргасны үр дүнд шилжилтийн бусад нөхцлүүдийг (өмнө нь 97-р параграфт дурдаж байсан нөхцлүүдийг) хассаны дараа, эдгээр шилжилтийн нөхцлүүдийг дахин илэрхийлсэн.

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг I-36

УСНББОУС 17, Үндсэн Хөрөнгө-д оруулсан нэмэлт өөрчлөлт

106-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 107Р параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

Шилжилтийн нөхцөл

...

106. УСНББОУС 17 (2001)-гийн шилжилтийн нөхцлүүд нь бүх үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрөх ба холбогдох хэмжилт, тодруулгыг хийхэд зориулан уг Стандартыг анх мөрдсөн өдрөөс эхлэн тав хүртэлх жилийн хугацааг байгууллагуудад олгодог. Өмнө нь УСНББОУС 17 (2001)-г мөрдөж байсан байгууллагууд нь УСНББОУС 17 (2001)-г анх мөрдсөн өдрөөс эхлэн энэхүү таван жилийн шилжилтийн хугацааны давуу талыг үргэлжлүүлэн ашиглаж болох юм. Эдгээр байгууллагууд нь 104-р параграфтаар шаардсан тодруулгуудыг мөн үргэлжлүүлэн хийнэ энэхүү шилжилтийн нөхцлүүдэд үндэслэсэн гэдгээ тодруулна. Хүлээн зөвшөөрөөгүй хөрөнгийн гол ангиудын талаархи мэдээллийг бас тодруулна. Байгууллага нь эдгээр шилжилтийн нөхцлүүдийн давуу талыг хоёр дахь буюу түүнийг дараагийн тайлант үеүдэд ашиглаж байгаа тохиолдолд өмнөх тайлангийн өдрөөр хүлээн зөвшөөрөөгүй боловч одоо хүлээн зөвшөөрсөн хөрөнгүүд буюу хөрөнгийн ангиудын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг тодруулах хэрэгтэй.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

107Р. 2018 оны 10 дугаар сард гаргасан, 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 106-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрднө. Дүрдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.

...

Дүгнэлтийн Үндэслэл

...

2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 17-д хийсэн хянан засварлалт

ДҮ15. УСНББОУС 17-д өмнө нь тусгасан байсан, таван жилийн шилжилтийн хугацааны давуу талыг угаасаа ашигладаг байгууллагуудад зориулсан шилжилтийн нөхцлүүдийг 106-р параграфт тусгасан. УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх-ийг гаргасны үр дүнд шилжилтийн бусад нөхцлүүдийг (өмнө нь 106-р параграфт дурдаж байсан нөхцлүүдийг) хассаны дараа, эдгээр шилжилтийн нөхцлүүдийг дахин илэрхийлсэн.

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг I-4

УСНББОУС 31, Биет Бус Хөрөнгө-д оруулсан нэмэлт өөрчлөлт

109-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 132Л параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

Тодорхой бус ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгө

...

Ашиглалтын хугацааны үнэлгээг хянах

...

109. ~~Өртгийн загвараар хэмждэг биет бус хөрөнгийн хувьд түүний ашиглалтын хугацааг~~ УСНББОУС 21 эсвэл УСНББОУС 26-гийн аль тохиромжтой стандартын дагуу ~~тодорхойгүй биш, харин тодорхой бөлгөн дахин үнэлж буй явдал биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг тодорхойгүй биш, харин тодорхой болгон дахин үнэлж буй явдал~~ нь уг хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болох шинж тэмдэг юм. Иймээс байгууллага нь УСНББОУС 21 эсвэл УСНББОУС 26-гийн аль тохиромжтой стандартын дагуу тодорхойлсон уг хөрөнгийн нөхөгдөх дүн буюу нөхөгдөх үйлчилгээний дүнг түүний дансны үнэтэй харьцуулах замаар үнэ цэнийн бууралтыг сорьж шалгах бөгөөд нөхөгдөх үйлчилгээний дүн эсвэл нөхөгдөх дүнгийн аль тохиромжтой дүнгээс давсан дансны үнийн аливаа хэтрэлтийг үнэ цэнийн бууралтын гарз гэж хүлээн зөвшөөрнө.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

132Л. 2018 оны 10 дугаар сард гаргасан, 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 109-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт (УСНББОУС 21, Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт болон УСНББОУС 26, Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт-ын Нэмэлт өөрчлөлтүүд)-ыг даган мөрдөнө.

...

Дүгнэлтийн Үндэслэл

...

2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 31-д хийсэн хянан засварлалт

ДҮ13. Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг дахин үнэлэх үедээ байгууллага нь тухайн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сорил хийхийг 109-р параграфтаар шаардсан байдаг. Энэ Стандартыг гаргаж байх үед зөвхөн өртгийн загварын дагуу хэмждэг биет бус хөрөнгийн хувьд ийм сорил хийхийг шаарддаг байсан. Харин 2016 оны 7-р сард Дахин Үнэлсэн Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт (УСНББОУС 21, Мөнгө Бий Болгодоггүй Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт болон УСНББОУС 26, Мөнгө Бий Болгогч Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт-ын Нэмэлт өөрчлөлтүүд)-ыг хэвлэн гаргасны дараа, бүх биет бус хөрөнгийн хувьд ийм сорил хийхийг шаарддаг болсон бөгөөд иймээс 109-р параграфт зохих нэмэлт өөрчлөлтийг оруулсан.

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг I-5

УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх-д оруулсан нэмэлт өөрчлөлт

78, 79, 123, 142-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 154Д параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Мөрдөх хугацаанд үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөхгүй чөлөөлөх нөхцлүүд

...

УСНББОУС 1, Санхүүгийн Тайлангийн Толилуулга

Зэрэгцүүлэгдэх мэдээлэл

...

78. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах сонголт хийсэн тохиолдолд шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан эсвэл энэхүү УСНББОУС-ын дагуу толилуулсан УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан нь дараах зүйлсийг агуулсан байна:

- (a) Өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээлэл бүхий нэг санхүүгийн байдлын тайлан ба аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдрийн өмнөх тайлант үеийн эхэн дэх эхлэлийн санхүүгийн байдлын тайлан;
- (б) Өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээлэл бүхий нэг санхүүгийн үр дүнгийн тайлан;
- (в) Өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээлэл бүхий нэг цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан;
- (г) Өмнөх тайлант үеийн зэрэгцүүлэгдэх мэдээлэл бүхий нэг мөнгөн гүйлгээний тайлан;
- (д) Анх мөрдөж буй байгууллага нь өөрийн батлагдсан төсвийг олон нийтэд танилцуулдаг тохиолдолд тусдаа нэмэлт санхүүгийн тайлан эсвэл санхүүгийн тайлан дахь төсвийн багана байдлаар харуулсан, тухайн тайлант жилийн төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн зэрэгцүүлэлт;
- (e) Холбогдох тодруулга, үүн дотроо 142-р параграфтаар шаардсанчлан зэрэгцүүлэгдэх мэдээлэл ба материаллаг тохируулгын талаархи хүүрнэсэн мэдээллийн тодруулга.

79. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулахгүй байх сонголт хийсэн тохиолдолд аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөний дараах түүний шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан эсвэл энэхүү УСНББОУС-ын дагуу толилуулсан УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан нь дараах зүйлсийг агуулсан байна:

- (a) Нэг санхүүгийн байдлын тайлан ба аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх эхлэлийн санхүүгийн байдлын тайлан;
- (б) Нэг санхүүгийн үр дүнгийн тайлан;
- (в) Нэг цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан;
- (г) Нэг мөнгөн гүйлгээний тайлан;

- (д) Анх мөрдөж буй байгууллага нь өөрийн батлагдсан төсвийг олон нийтэд танилцуулдаг бол тусдаа нэмэлт санхүүгийн тайлан эсвэл санхүүгийн тайлан дахь төсвийн багана байдлаар харуулсан, тухайн тайлант жилийн төсөв ба гүйцэтгэлийн дүнгийн зэрэгцүүлэлт;
- (е) Холбогдох тодруулга ба 142-р параграфтаар шаардсанчлан материаллаг тохируулгын талаархи хүүрнэсэн мэдээллийн тодруулга.

...

УСНББОУС 30, Санхүүгийн Хэрэглүүр: Тодруулга

123. Анх удаа мөрдөж буй байгууллага нь 78-р параграфын дагуу зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах сонголт хийсэн тохиолдолд тухайн зэрэгцүүлэгдэх тайлант үед санхүүгийн хэрэглүүрээс үүссэн эрсдлийн шинж төрөл ба хэмжээний талаархи мэдээллийг түүний шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланд эсвэл УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланд толилуулахыг уг байгууллагаас шаардахгүй.

...

Тохируулгын тайлан

142. Анх удаа мөрдөж буй байгууллага нь шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан эсвэл УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлангийн тодруулгад дараах зүйлсийг толилуулна:
- (а) Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу тайлагнасан цэвэр хөрөнгө/өмчийн үлдэгдлийг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх цэвэр хөрөнгө/өмчийн эхний үлдэгдэл болгох тохируулгын тайлан;
 - (б) Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу тайлагнасан хуримтлагдсан ашиг, алдагдлыг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх хуримтлагдсан ашиг, алдагдалын эхний үлдэгдэл болгох тохируулгын тайлан.

Өөрийн өмнөх санхүүгийн тайландаа нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурийг мөрдөж байсан, анх удаа мөрдөж буй байгууллага нь ийм тохируулгын тайланг толилуулах шаардлагагүй юм.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

- 154Д. 2018 оны 10 дугаар сард гаргасан, 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 78, 79, 123, 142-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө.

...

Дүгнэлтийн Үндэслэл

...

Анх удаа мөрдсөн талаархи мэдээллийн толилуулга

Аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөний дараа, зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах

...

ДҮ25. Өртөг-өгөөжийн шалгуурыг харгалзан үзсэнээр, УСНББОУСЗ нь аккруэл суурьт УСНББОУС-ын мөрдөлтийг дэмжихийн тулд зэрэгцүүлэгдэх мэдээллийн толилуулгын хувьд УСНББОУС 1-д заасан, одоогийн арга хандлагыг хэвээр хадгалахаа мэдэгдсэн. Иймээс энэхүү УСНББОУС нь өөрийн шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан эсвэл УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланд зэрэгцүүлэгдэх мэдээллийг уг анх удаа мөрдөж буй байгууллага тусгах шаардлага оруулахгүй байснаар зөвхөн зэрэгцүүлэгдэх мэдээллээс чөлөөлөгдөхийг дэмждэг.

ДҮ26. Анх удаа мөрдөж буй байгууллага нь зэрэгцүүлэгдэх мэдээлэл толилуулахгүй байх сонголт хийсэн тохиолдолд аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр уг анх удаа мөрдөж буй байгууллагын шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан хамгийн наад зах нь, нэг санхүүгийн байдлын тайлан ба эхлэлийн санхүүгийн байдлын тайланг агуулсан байх хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрсөн.

...

2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 33-д хийсэн хянан засварлалт

ДҮ119. Зэрэгцүүлэгдэх мэдээлэл бэлтгэхээс чөлөөлөх заалтыг аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөний дараа гаргасан анхны санхүүгийн тайланд эсвэл шилжилтийн хугацаанд гаргасан бүх санхүүгийн тайланд мөрдөх эсэхэд оролцогч талууд итгэлгүй байгааг УСНББОУСЗ нь УСНББОУС 33-ыг гаргасны дараа мэдсэн. 77-р параграфт байгууллагын “УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан” гэж дурдсан боловч бусад параграфуудад байгууллагын “шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн санхүүгийн тайлан” гэж заасан. Уг чөлөөлөх нөхцөл нь аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөний дараа гаргасан зөвхөн анхны санхүүгийн тайланд хамаарна гэдгийг тодруулахын тулд УСНББОУСЗ нь бусад параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн.

Хэрэгжүүлэх заавар удирдамж

Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 33-ыг дагалдах боловч түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

Зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах

ХЗУ29. УСНББОУС 33-ын 78-р параграф нь шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланд эсвэл энэхүү УСНББОУС-ын дагуу толилуулсан УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланд зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулахыг байгууллагаас шаардахгүй боловч дэмждэг. Зэрэгцүүлэгдэх мэдээллийг толилуулах шийдвэр нь зөвхөн тухайн толилуулсан мэдээллийн хэмжээ төдийгүй УСНББОУС-ыг мөрдөх өдөрт бас нөлөөлдөг.

...

ХЗУ35. УСНББОУС 33-ын 142-р параграф нь нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу тайлагнасан цэвэр хөрөнгө/өмчийн эцсийн үлдэгдлийг уг шилжилтийн үеийн УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлан эсвэл УСНББОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайланд УСНББОУС-ын дагуу тайлагнасан цэвэр хөрөнгө/өмчийн эхний үлдэгдэл болгох тохируулгын тайланг толилуулахыг анх удаа мөрдөж буй байгууллагаас шаарддаг. Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу тайлагнасан хуримтлагдсан ашиг, алдагдлыг УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх хуримтлагдсан ашиг, алдагдлын эхний үлдэгдэл болгох тохируулгын тайланг бас толилуулдаг.

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг I-6

УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх-д оруулсан нэмэлт өөрчлөлт

ДҮ109, ХЗУ91-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 33-ыг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

Үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөхгүй чөлөөлөх нөхцлүүд

...

УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж

ДҮ109. Анх удаа мөрдөж буй байгууллага нь өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтийн хувьд чөлөөлөлт олгодог нөхцлийн давуу талыг ашигласандаа тохиолдолд тус байгууллага нь тогтоосон тэтгэмжийн үүргийн өнөөгийн үнэ цэнийн тухайн тайлант болон өмнөх дөрвөн жилийн дүнгүүд, хөтөлбөрийн хөрөнгийн бодит үнэ цэнэ, уг хөтөлбөрийн ашиг, алдагдал болон УСНББОУС 25-аар 39-ээр гүйцээх горимоор мөрдөхөөр шаардсан тохируулгын талаархи мэдээллээр хангахна хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ нь УСНББОУС 33-ыг боловсруулах үедээ мөн хүлээн зөвшөөрсөн. УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж-ийг 2016 оны 7-р сард гаргасан. Туршлагын залруулгын талаархи мэдээллийг тодруулах УСНББОУС 25-ын 141(с) параграфын шаардлагыг УСНББОУС 39-д оруулаагүй учраас түүний 107-р параграфыг УСНББОУС 39-өөс хассан.

...

Хэрэгжүүлэх заавар удирдамж

Энэхүү хэрэгжүүлэх заавар удирдамж нь УСНББОУС 33-ыг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

Толилуулга ба тодруулга

...

УСНББОУС 33, Аккруэл Суурьт УСНББОУС-ыг Анх Удаа Мөрдөх-д заасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд ба заалтуудын товчоо

ХЗУ91. Аккруэл суурьт бусад УСНББОУС-д тусгасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд ба заалтуудыг дараах схемд товчоолон харуулав.

...

УСНББОУС	Олгосон шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд							
	Үгүй	Тийм						
		Төсөөлөн тооцсон өртөг	Хүлээн зөвшөөрөлтөөс 3	Хэмжилтээс 3 жилийн	Хүлээн зөвшөөрөлт ба/буюу	Тодруулгаас 3 жилийн	Ажил гүйлгээ, үлдэгдэл,	Бусад

2018 ОНЫ УСНББОУС-ЫН САЙЖРУУЛАЛТУУД

			жилийн хугацаанд чөлөөлөх	хугацаанд чөлөөлөх	хэмжилтээс 3 жилийн хугацаанд чөлөөлөх	хугацаанд чөлөөлөх	орлого, зардлыг устгаж цэвэрлэх	
УСНББОУС 25, Ажилтны Тэтгэмж (УСНББОУС 39, Ажилтны Тэтгэмж)			√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрөөгүй тогтоосон тэтгэмжийн хөтөлбөр ба ажилтны урт хугацааны бусад тэтгэмж	√ Нягтлан бодох бүртгэлийн өмнөх суурийн дагуу хүлээн зөвшөөрсөн тогтоосон тэтгэмж болон ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн хувьд				<ul style="list-style-type: none"> • Анхны өр төлбөрийг хэрхэн тодорхойлох талаархи заалт • Хуримтлагдсан актуар олз ба гарзыг салган тусгаарлахгүй байх заалт • Туршлагад үндэслэсэн тохируулгын талаархи хэтийн мэдээлэл

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг I-7

УСНББОУС 34, Тусдаа Санхүүгийн Тайлан-д оруулсан нэмэлт өөрчлөлт

14, 22, 30-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 32В параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Тусдаа санхүүгийн тайланг бэлтгэх

...

14. УСНББОУС 35-ын 56-р параграфт заасанчлан, хэрэв хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй байгууллага дахь өөрийн хөрөнгө оруулалтыг УСНББОУС 29-ийн (эсвэл УСНББОУС 41-ийн мөрддөг тохиолдолд уг Стандартын) дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих шаардлагатай бол хяналтанд буй байгууллага дахь уг хөрөнгө оруулалтыг өөрийн тусдаа санхүүгийн тайландаа мөн энэхүү арга замаар тайлагнана. Өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш, хяналт тавигч байгууллага нь УСНББОУС 35-ын 58-р параграфт заасанчлан, хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын хөрөнгө оруулалтыг УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ба уг хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын бусад хөрөнгө, ор-толбөр, орлого, зардлыг нэгтгэх шаардлагатай бол тус байгууллага нь хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллага дахь өөрийн тэрхүү хөрөнгө оруулалтыг өөрийн тусдаа санхүүгийн тайландаа 12-р параграфын дагуу мөн энэхүү арга замаар тайлагнана.

...

Тодруулга

...

22. Өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш, хяналт тавигч байгууллага нь УСНББОУС 35-ын 58-р параграфын шаардлагуудыг мөрдөх шаардлагатай бол УСНББОУС 35-ын 56-р параграфт заасанчлан, хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын хөрөнгө оруулалтыг УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ба уг хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын бусад хөрөнгө, ор-толбөр, орлого, зардлыг нэгтгэх шаардлагатай бол энэ тухай тодруулга хийнэ. Тус байгууллага нь хөрөнгө оруулалтын байгууллага дахь өөрийн хөрөнгө оруулалтыг тусдаа санхүүгийн тайланд хэмжихдээ сонгосон, нягтлан бодох бүртгэлийн бодлогоо тодруулж, УСНББОУС 38, Бусад Байгууллагууд дахь Хувь Оролцооны Тодруулга-аар шаардсан, хөрөнгө оруулалтын байгууллагуудад хамаарах тодруулгыг мөн толилуулна.

...

Шилжилтийн нөхцөл

30. Стандартыг анх мөрдсөн өдөр, өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш боловч УСНББОУС 35-ын 56-р 58-р параграфт заасанчлан, хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын дахь өөрийн хөрөнгө оруулалтыг УСНББОУС 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих ба уг хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын бусад хөрөнгө, ор-толбөр, орлого, зардлыг нэгтгэх шаардлагатай, хяналт тавигч байгууллага нь тэрхүү хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллага дахь өөрийн хөрөнгө оруулалтыг тусдаа санхүүгийн тайландаа тайлагнахдаа 24-29-р параграфт заасан, шилжилтийн нөхцлүүдийг ашиглана.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

32В. 2018 оны 10 дугаар сард гаргасан, 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 14, 22, 30-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

...

Дүгнэлтийн Үндэслэл

...

2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 34-д хийсэн хянан засварлалт

ДҮ9А. Хяналт тавигч байгууллага нь зүйлсийг өөрийн тусдаа санхүүгийн тайланд нэгтгэдэггүй тул 14 ба 30-р параграфын (хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллагын зарим үлдэгдлүүдийг тусдаа санхүүгийн тайланд нэгтгэх талаархи) шаардлагуудад нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгтэй гэдгийг УСНББОУСЗ нь УСНББОУС 34-ийг гаргасны дараа мэдсэн. Өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага биш, хяналт тавигч байгууллага нь хяналтанд буй хөрөнгө оруулалтын байгууллага дахь өөрийн хөрөнгө оруулалтыг УСНББОУС 34-ийн 12-р параграфын дагуу тусдаа санхүүгийн тайландаа хэмжихийг УСНББОУСЗ нь зөвшөөрөхөөр шийдвэрлэсэн. УСНББОУСЗ нь энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-д тусган оруулсан.

ХЭСЭГ II: СТОУС-ТАЙ НИЙЦҮҮЛЭХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮД**Зорилго**

3. 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын Хэсэг II-ын зорилго нь НББОУСЗ-ийн СТОУС-ын Сайжруулалтууд төслүүд, Явцуу Цар Хүрээний Нэмэлт Өөрчлөлт төслүүд, СТОУС-ын Тайлбарын Хорооны Тайлбаруудад тус тус үндэслэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад оруулсан нэмэлт өөрчлөлтүүдтэй нийцүүлэхийн тулд УСНББОУС-д Сайжруулалт хийх явдал юм.

Харгалзан үзсэн УСНББОУС

4. 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд нь хоорондоо хамааралгүй нэмэлт өөрчлөлтүүдийн цуглуулга байдлаар УСНББОУС-д хийсэн материаллаг бус өөрчлөлтүүдийг авч үзсэн. Хэсэг II-т тусгасан нэмэлт өөрчлөлтүүд нь жил тутмын сайжруулалтын хэлэлцүүлэг, НББОУСЗ-ийн явцуу цар хүрээний нэмэлт өөрчлөлт төслүүд, СТОУС-ын Тайлбарын Хорооны Тайлбаруудад үндэслэсэн.

Хэсэг II-ын нэмэлт өөрчлөлтүүд нь НББОУСЗ-ийн дараах нэмэлт өөрчлөлтүүдээс бий болсон:

Нэмэлт өөрчлөлт	УСНББОУС	Өөрчлөлтийн товч тойм
<i>2011-2013 оны хооронд СТОУС-уудад Хийсэн Жилийн Сайжруулалтууд (2013 оны 12-р сард гаргасан)</i>		
Хэсэг II-1	УСНББОУС 16, <i>Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө</i>	Үл хөдлөх хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө эсвэл эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгө гэж ангилах тохиолдолд (УСНББОУС 40-өөр мэдэгдэхүйц өөрчлөлтийг угаасаа хийсэн) УСНББОУС 40, <i>Улсын Секторын Нэгдэл</i> ба УСНББОУС 16-гийн хоорондох харилцан уялдаатай холбоотойгоор гарчгуудыг шинэчлэн өөрчлөх.
<i>Тодруулгын Санаачлага (НББОУС 7-гийн Нэмэлт өөрчлөлт) (2016 оны 01-р сард гаргасан)</i>		
Хэсэг II-2	УСНББОУС 2, <i>Мөнгөн Гүйлгээний Тайлан</i>	Санхүүгийн үйл ажиллагааны улмаас өр төлбөрт гарсан өөрчлөлтийг үнэлэх боломжийг тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгохын тулд тодруулгыг нэмж оруулах.
<i>Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгийн Шилжүүлэг (НББОУС 40-ийн Нэмэлт өөрчлөлт) (2016 оны 12-р сард гаргасан)</i>		
Хэсэг II-3	УСНББОУС 16, <i>Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө</i>	Ашиглалтын өөрчлөлт нь дараах зүйлстэй холбоотой гэсэн зарчмыг тусгахын тулд хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн шилжүүлгэд хамаарах шаардлагуудад нэмэлт өөрчлөлт оруулах: (а) үл хөдлөх хөрөнгө нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тодорхойлолтыг хангадаг эсвэл хангахаа больсон эсэх үнэлгээ; (б) ашиглалтын өөрчлөлт гарч тохиолдсон гэдгийг дэмжих нотолгоо. Шилжүүлэг хийгдэх нөхцөл байдлын жагсаалтыг энэ зарчимд нийцсэн жишээнүүдийн иж бүрэн бус жагсаалт гэж дахин тодорхойлсон.
<i>2014-2016 оны хооронд СТОУС-уудад Хийсэн Жилийн Сайжруулалтууд (2016 оны 12-р сард гаргасан)</i>		
Хэсэг II-4	УСНББОУС 36, <i>Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт</i>	Байгууллага нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалт нэг бүрийн хувьд өмчийн аргыг хэрэглэх эсвэл тухайн хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр хэмжих сонголт хийх боломжтой гэдгийг тодорхой болгож өгөх.
<i>СТОУТХ-ны Тайлбар 22 Гадаад Валютын Ажил Гүйлгээ ба Урьдчилгаа Төлбөр (2016 оны 12-р сард гаргасан)</i>		
Хэсэг II-5а	УСНББОУС 4, <i>Гадаад Валютын Ханийн Өөрчлөлтийн Үр Нөлөө;</i>	Байгууллага нь холбогдох хөрөнгө, зардал буюу орлогыг хүлээн зөвшөөрөхөөс өмнө, урьдчилгаа төлбөр хүлээн авсан эсвэл төлснөөс үүссэн, мөнгөн бус зүйлсийн хөрөнгө болон

2018 ОНЫ УСНББОУС-ЫН САЙЖРУУЛАЛТУУД

Хэсэг II-56	УСНББОУС 33, <i>Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх;</i>	мөнгөн зүйлсийн бус өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх үед ажил гүйлгээг хэрхэн тайлагнах эсэхийг тодруулж өгөх.
<i>2015-2017 оны хооронд СТОУС®-ын Стандартуудад Хийсэн Жилийн Сайжруулалтууд (2017 оны 12-р сард гаргасан)</i>		
Хэсэг II-6	УСНББОУС 37, <i>Хамтын Хэлэлцээр</i>	Оролцогч тал нь хамтын хяналтыг олж авсан тохиолдолд уг хамтын үйл ажиллагаанд өмнө нь эзэмшиж байсан хувь оролцоог хэрхэн тайлагнахыг тодруулж өгөх.
Хэсэг II-7	УСНББОУС 40, <i>Улсын Секторын Нэгдэл</i>	Оролцогч тал нь хамтын үйл ажиллагааны хяналтыг олж авсан тохиолдолд уг хамтын үйл ажиллагаанд өмнө нь эзэмшиж байсан хувь оролцоог хэрхэн тайлагнахыг тодруулж өгөх.
Хэсэг II-8	УСНББОУС 5, <i>Зээлийн Өртөг</i>	Шалгуур хангах хөрөнгийг түүний зориулалтын дагуу ашиглах буюу борлуулахад бэлэн болсон тохиолдолд байгууллага нь уг шалгуур хангах хөрөнгийг олж эзэмшихийн тулд тусгайлан авсан зээлийг ерөнхий зориулалт бүхий зээлэнд хамруулна гэдгийг тодруулж өгөх.
<i>Хөтөлбөрийн Нэмэлт Өөрчлөлт, Цомхотгол буюу Барагдуулалт (НББОУС 19-ийн Нэмэлт өөрчлөлт) (2018 оны 2-р сард гаргасан)</i>		
Хэсэг II-9	УСНББОУС 19, <i>Ажилтны Тэтгэмж</i>	Хөтөлбөрийн өөрчлөлтийн дараах, тухайн тайлант үеийн үлдсэн хугацааны хувьд одоогийн үйлчилгээний зардал болон цэвэр хүүг тодорхойлохын тулд уг хөтөлбөрийн өөрчлөлттэй (нэмэлт өөрчлөлт, цомхотгол буюу барагдуулалттай) холбоотой дахин хэмжилтээс бий болсон, тэрхүү шинэчлэн баяжуулсан төсөөллүүдийг ашиглахыг байгууллагаас шаардах.

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг II-1

УСНББОУС 16, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө*-д оруулсан нэмэлт өөрчлөлт

8 ба 9-р параграфын өмнө байсан гарчгуудыг хасаж, 8-р параграфын өмнө шинэ гарчиг нэмж оруулсан. Харахад хялбар болгох үүднээс 8 ба 9-р параграфыг энд тусгасан боловч тэдэнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Үл хөдлөх хөрөнгийг Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө эсвэл Эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгө гэж ангилах

~~Үйл ажиллагааны түрээсийн дагуу түрээслэгчийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн хувь өрөлцөө~~

...

8. **Үйл ажиллагааны түрээсийн дагуу түрээслэгчийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоог зөвхөн дараах тохиолдолд хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж ангилан тайлагнаж болно: (а) уг үл хөдлөх хөрөнгө нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тодорхойлолтыг ямар нэг байдлаар хангах, (б) түрээслэгч нь тэрхүү хүлээн зөвшөөрсөн хөрөнгийн хувьд 42-64-р параграфт заасан бодит үнэ цэнийн загварыг ашигладаг байх. Ангиллын энэхүү хувилбарыг үл хөдлөх хөрөнгө нэг бүрээр ашиглаж болох юм. Гэвч үйл ажиллагааны түрээсийн дагуу эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн ийм нэг хувь оролцооны хувьд ангиллын энэхүү хувилбарыг сонгосон тохиолдолд хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж ангилсан бүх үл хөдлөх хөрөнгийг бодит үнэ цэнийн загвар ашигласнаар тайлагнана. Ангиллын энэ хувилбарыг сонгосон тохиолдолд ингэж ангилсан аливаа хувь оролцоог 85-89-р параграфтаар шаардсан тодруулгад тусган оруулна.**

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

9. Улсын секторын байгууллагууд нь түрээсийн орлогоор болон капиталын үнийн өсөлтөөр ашиг олохын тулд үл хөдлөх хөрөнгийг эзэмшиж болох олон нөхцөл байдал байдаг. Жишээлбэл; засгийн газрын үл хөдлөх хөрөнгийн багцыг худалдаа арилжааны сууриар удирдан зохицуулахын тулд улсын секторын байгууллагыг үүсгэн байгуулж болох юм. Энэ тохиолдолд уг байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад дахин борлуулахаар эзэмшиж байгаагаас бусад, үл хөдлөх хөрөнгө нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тодорхойлолтыг хангадаг. Улсын секторын бусад байгууллагууд нь түрээсийн буюу капиталын үнийн өсөлтийн зорилгоор үл хөдлөх хөрөнгийг бас эзэмшиж болох бөгөөд өөрийн бусад үйл ажиллагааг (үйлчилгээ үзүүлэх) санхүүжүүлэхийн тулд түүнээс бий болсон мөнгийг ашиглаж болох юм. Жишээлбэл; их сургууль эсвэл орон нутгийн засаг захиргаа нь бүтээгдэхүүн үйлдвэрлэх буюу үйлчилгээ үзүүлэх биш, харин мөнгө санг бий болгохын тулд гаднын талуудад арилжааны сууриар түрээслэх зорилгоор барилгыг өмчилдөг байж болно. Ийм үл хөдлөх хөрөнгө нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тодорхойлолтыг бас хангана.

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг II-2

УСНББОУС 2, Мөнгөн Гүйлгээний Тайлан-д оруулсан нэмэлт өөрчлөлт

55А-55Д параграф болон холбогдох гарчгийг шинээр нэмсэн. Мөн 63Е параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур зурсан.

...

Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн өөрчлөлт

55А. Байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн өөрчлөлтийг, үүн дотроо мөнгөн гүйлгээнээс үүссэн өөрчлөлт ба мөнгөн бус өөрчлөлтийн аль алиныг үнэлэх боломжийг санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох тодруулгыг бэлтгэх хэрэгтэй.

55Б. 55А параграфын шаардлагын ханган биелүүлэхэд шаардлагатай тохиолдолд байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн дараах өөрчлөлтийг тодруулна:

(а) Санхүүжилтийн мөнгөн гүйлгээнээс үүссэн өөрчлөлт;

(б) Хяналтанд буй байгууллагууд буюу бусад үйл ажиллагаан дахь хяналтыг олж авснаас эсвэл алдсанаас үүссэн өөрчлөлт;

(в) Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө;

(г) Бодит үнэ цэнийн өөрчлөлт; ба

(д) Бусад өөрчлөлт.

55В. Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөр гэдэг нь түүний мөнгөн гүйлгээ эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээ нь мөнгөн гүйлгээний тайланд санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ гэж ангилагдсан буюу ангилагдах өр төлбөр юм. Түүнчлэн, санхүүгийн хөрөнгөөс үүссэн мөнгөн гүйлгээг санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээнд тусгасан эсвэл ирээдүйн мөнгөн гүйлгээг нь тэрхүү мөнгөн гүйлгээнд тусган оруулах бол тухайн санхүүгийн хөрөнгийн (жишээлбэл; санхүүгийн үйл ажиллагаанаас үүсэх өр төлбөрт хейж хийдэг хөрөнгийн) өөрчлөлтийн хувьд 55А параграфын тодруулгын шаардлагыг бас мөрдөнө.

55Г. 55А параграфын тодруулгын шаардлагыг биелүүлэх нэг арга зам нь санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн, үүн дотроо 55Б параграфт тодорхойлсон өөрчлөлтийн хувьд санхүүгийн байдлын тайлан дахь эхний болон эцсийн үлдэгдэл хоорондох тохируулгын тайланг бэлтгэх явдал юм. Байгууллага нь ийм тохируулгын тайланг толилуулдаг тохиолдолд тус байгууллага нь уг тохируулгын тайлан дахь зүйлсийг санхүүгийн байдлын тайлан болон мөнгөн гүйлгээний тайлантай холбон уялдуулах боломжийг тухайн санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд олгох хангалттай мэдээллээр хангах хэрэгтэй.

55Д. Хэрэв байгууллага нь бусад хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тодруулгын хамтаар уг 55А параграфтаар шаардсан тодруулгыг бэлтгэдэг бол тус байгууллага нь санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн өөрчлөлтийг тэдгээр бусад хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтөөс тусад нь тодруулна.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

63Е. 2018 оны 10 дугаар сард гаргасан, 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 55А-55Д параграфуудыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2021 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Байгууллага нь эдгээр

нэмэлт өөрчлөлтүүдийг анх удаа мөрдөж байгаа тохиолдолд өмнөх тайлант үеүдийн зэрэгцүүлэгдэх мэдээллийг бэлтгэх шаардлагагүй юм.

...

Дүгнэлтийн Үндэслэл

...

2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 2-т хийсэн хянан засварлалт

ДҮЗ. УСНББОУСЗ нь 2016 оны 01-р сард НББОУСЗ-өөс гаргасан, Тодруулгын Санаачлага (НББОУС 7-гийн Нэмэлт өөрчлөлт) гэж нэрлэгдэх, явцуу цар хүрээний нэмэлт өөрчлөлтүүдэд тусгагдсан НББОУС 7-гийн хянан засварлалт, түүнчлэн Дүгнэлтийн Үндэслэлд заасан, НББОУСЗ-ийн ийм нэмэлт өөрчлөлт хийх болсон шалтгаан үндэслэлийг нягталж үзээд эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг үл мөрдөх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэдэгтэй ерөнхийдөө санал нэгдсэн. Энэхүү нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд байгууллагуудад цаг хугацаа шаардлагатай гэдгийг УСНББОУСЗ хүлээн зөвшөөрч, 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-д дурдсан, бусад нэмэлт өөрчлөлтүүдээс хоёр жилийн дараа буюу 2021 оны 01-р сарын 01-нээр түүний хүчин төгөлдөр болох хугацааг тогтоосон.

...

Үлгэрчилсэн жишээ

Энэхүү жишээ нь УСНББОУС 2-ыг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

Мөнгөн гүйлгээний тайлан (Санхүүгийн байгууллагаас бусад, байгууллагад зориулав)

Шууд аргаар бэлтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (27(а) параграф)

...

Мөнгөн гүйлгээний тайлангийн тодруулга

...

(г) Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн тохируулгын тайлан

	<u>20X1</u>	<u>Мөнгөн гүйлгээ</u>	<u>Мөнгөн бус өөрчлөлт</u>		<u>20X2</u>
			<u>Худалдан авалт</u>	<u>Шинэ түрээс</u>	
<u>Урт хугацаат зээл</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>
<u>Түрээсийн өр төлбөр</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>
<u>Урт хугацаат өр</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>

...

Шууд бус аргаар бэлтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (27(б) параграф)

Улсын секторын байгууллага - 20X2 оны 12-р сарын 31-нээр дуусгавар болсон жилийн Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянгачилсан дүнгээр)

...

Мөнгөн гүйлгээний тайлангийн тодруулга

2018 ОНЫ УСНББОУС-ЫН САЙЖРУУЛАЛТУУД

...

(г) Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн тохируулгын тайлан

	20X1	Мөнгөн гүйлгээ	Мөнгөн бүс өөрчлөлт		20X2
			Худалдан авалт	Шинэ түрээс	
<u>Урт хугацаат зээл</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>
<u>Түрээсийн өр төлбөр</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>
<u>Урт хугацаат өр</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>

Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн тохируулгын тайлан

1. Энэ жишээ нь 55А-55Д параграфтаар шаардсан, тодруулгыг бэлтгэх боломжит нэг арга замыг үлгэрчлэн харуулсан.
2. Энэ жишээнд зөвхөн тайлант үеийн дүнгүүдийг харуулсан. Өмнөх тайлант үеийн харгалзах дүнгүүдийг УСНББОУС 1, Санхүүгийн Тайлангийн Толилуулга-ын дагуу толилуулах шаардлагатай юм.

	20X1	Мөнгөн гүйлгээ	Мөнгөн бүс өөрчлөлт			20X2
			Худалдан авалт	Гадаад валютын ханшийн өөрчлөлт	Бодит үнэ цэнийн өөрчлөлт	
<u>Урт хугацаат өр</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>
<u>Богино хугацаат өр</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>
<u>Түрээсийн өр төлбөр</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>
<u>Урт хугацаат өрд хейж хийхийн тулд эзэмшиж буй хөрөнгө</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>
<u>Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн нийт өр төлбөр</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>	<u>X</u>

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг II-3

УСНББОУС 16, *Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгө*-д оруулсан нэмэлт өөрчлөлт

66, 68-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 100Б-100Г болон 101И параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Шилжүүлэг

66. **Хөрөнгийн ашиглалтанд өөрчлөлт орсон бөгөөд дараах зүйлсээр нотлогдсон бол, зөвхөн тийм тохиолдолд байгууллага нь үл хөдлөх хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд эсвэл хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөөс үл хөдлөх хөрөнгөнд шилжүүлнэ. Үл хөдлөх хөрөнгө нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн тодорхойлолтыг хангасан эсвэл хангааа больсон бөгөөд ашиглалтанд өөрчлөлтийн нотолгоо байгаа тохиолдолд ашиглалтын өөрчлөлт хийгдсэн байна. Хөрөнгийн ашиглалтын талаархи удирдлагын санаа зорилго нь дангаараа ашиглалтын өөрчлөлтийн нотолгоо болохгүй юм. Ашиглалтын өөрчлөлтийн нотолгооны жишээнд дараах зүйлс хамаарна:**

- (à) Тухайн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгөнд шилжүүлэхэд хүргэх эзэн-ашиглалт эхлэх эсвэл эзэн-ашиглалт болгох зорилготой хөгжүүлэлт хийж эхлэх;
- (á) Борлуулах үүднээс, тухайн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг бараа материалд шилжүүлэх зорилгоор хөгжүүлэлт хийж эхлэх;
- (â) Эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгөөс хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд шилжүүлэхэд хүргэх эзэн-ашиглалт дуусах; эвэв ба
- (ã) Бараа материалаас хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд шилжүүлэхэд хүргэх, нөгөө талд (арилжааны сууриар) түрээслэх үйл ажиллагааны түрээс эхлэж үүсгэх; ба
- (ä) [Хассан]

...

68. ~~Борлуулах зорилго бүхий хөгжүүлэлтээр нотлогдох, ийм ашиглалтын өөрчлөлт гарсан бол, зөвхөн тийм тохиолдолд байгууллага нь уг үл хөдлөх хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөөс бараа материал болгон шилжүүлэхийг 66(б) параграфтаар шаардсан байдаг. Байгууллага нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг хөгжүүлэлт хийхгүйгээр данснаас хасахаар шийдвэрлэсэн тохиолдолд уг үл хөдлөх хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх (санхүүгийн байдлын тайлангаас хасах) хүртэл хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө гэж бүртгэсэн хэвээр байх бөгөөд бараа материал гэж үзэхгүй дахин ангилахгүй. Үүнтэй адилаар, хэрэв байгууллага нь одоо байгаа хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг ирээдүйд хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө байдлаар ашигласан хэвээр байхын тулд дахин хөгжүүлж эхэлсэн бол уг үл хөдлөх хөрөнгө нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө хэвээр үлдэх бөгөөд тухайн дахин хөгжүүлэлтийн явцад эзэн-ашигладаг үл хөдлөх хөрөнгө гэж дахин ангилахгүй.~~

...

Шилжилтийн нөхцөл

...

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн шилжүүлэг

2018 ОНЫ УСНББОУС-ЫН САЙЖРУУЛАЛТУУД

100Б. 2018 оны 10 дугаар сард гаргасан, 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 66 ба 68-р параграфуудад нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь нэмэлт өөрчлөлтүүдийг анх мөрдөх жилийн тайлант үеийн эхэнд (анх мөрдөх өдөр) буюу түүнээс хойш гарч тохиолдсон ашиглалтын өөрчлөлтүүдэд эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөнө. Анх мөрдөх өдөр байгууллага нь тухайн өдрөөр эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн ангиллыг дахин үнэлэх бөгөөд хэрэв боломжтой бол тэрхүү өдрөөр оршин буй нөхцөл байдлыг тусгахын тулд 9-18-р параграфыг мөрдсөнөөр уг үл хөдлөх хөрөнгийг дахин ангилна.

100В. 100Б параграфын шаардлагуудыг үл харгалзан, байгууллага нь үр дагаврын талаархи мэдлэгийг ашиглахгүйгээр буцаан мөрдөх боломжтой зөвхөн тийм тохиолдолд 66 ба 68-р параграфын нэмэлт өөрчлөлтүүдийг УСНББОУС 3-ын дагуу буцаах горимоор мөрдөхийг түүнд зөвшөөрдөг.

100Г. Хэрэв байгууллага нь анх мөрдөх өдөр үл хөдлөх хөрөнгийг 100Б параграфын дагуу дахин ангилдаг бол тус байгууллага нь дараах зүйлсийг гүйцэтгэнэ:

(а) 70-75-р параграф дахь шаардлагуудыг мөрдсөнөөр уг дахин ангиллыг тайлагнана. 70-75-р параграфыг мөрдөх үедээ байгууллага нь:

(i) Ашиглалтын өөрчлөлтийн өдрийг анх мөрдөх өдөр болгосон аливаа харилцан лавлагаа, ишлэлийг унших; ба

(ii) 70-75-р параграфын дагуу ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх байсан аливаа дүнг уг анх мөрдөх өдөр хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдлийн залруулга байдлаар хүлээн зөвшөөрнө.

(б) 100Б параграфын дагуу хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөнд эсвэл хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөөс дахин ангилсан дүнгүүдийг тодруулна. 87 болон 90-р параграфтаар шаардсанчлан, тухайн тайлант үеийн эхэн ба эцэс дэх хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн дансны үнийн тохируулгын тайлангийн нэг хэсэг байдлаар дахин ангилсан дүнгүүдэд байгууллага нь тодруулга хийнэ.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

101Ж. 2018 оны 10 дугаар сард гаргасан, 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 66, 68-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 100Б-100Г параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

...

Дүгнэлтийн Үндэслэл

...

2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 16-д хийсэн хянан засварлалт

ДҮҮ11. УСНББОУС3 нь 2016 оны 12-р сард НББОУС3-өөс гаргасан, Хөрөнгө Оруулалтын Зориулалттай Үл Хөдлөх Хөрөнгийн Шилжүүлэг (НББОУС 40-ийн Нэмэлт өөрчлөлт) гэж нэрлэгдэх, явцуу цар хүрээний нэмэлт өөрчлөлтүүдэд тусгагдсан НББОУС 40-ийн хянан засварлалт, түүнчлэн Дүгнэлтийн Үндэслэлд заасан, НББОУС3-ийн ийм нэмэлт өөрчлөлт хийх болсон шалтгаан үндэслэлийг нягталж үзээд эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг үл мөрдөх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэдэгтэй ерөнхийдөө санал нэгдсэн.

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг II-4

УСНББОУС 36, Хараат Байгууллага ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт-д оруулсан нэмэлт өөрчлөлт

24-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 51Д параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Өмчийн аргын хэрэглээ

...

Өмчийн арга ашиглахаас чөлөөлөгдөх

...

24. Жижиг дунд үйлдвэрт хөрөнгө оруулагч байгууллагууд, хамтын сан, хамтын итгэлцлийн сан болон тэдгээртэй адилтгах байгууллагууд, үүн дотроо хөрөнгө оруулалттай хосолсон даатгалын сан гэх мэт байгууллага нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтыг шууд ба шууд бусаар эзэмшдэг тохиолдолд уг байгууллага нь ~~тэдгээр хараат байгууллага болон хамтарсан үйлдвэр дэх тэрхүү~~ хөрөнгө оруулалтыг УСНББОУС 41² 29-ийн дагуу ашиг, алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр хэмжих сонголт хийж болно. Тухайн хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэрийг анх хүлээн зөвшөөрөх үед байгууллага нь хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр нэг бүрийн хувьд энэхүү сонголтыг тус тусад нь хийнэ. Тодорхойлолт ёсоор хөрөнгө оруулалтын байгууллага нь өрийн хөрөнгө оруулалтуудын хувьд ийм сонголтыг хийнэ.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

- 51Д. 2018 оны 10 дугаар сард гаргасан, 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 24-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед уг нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

...

Дүгнэлтийн Үндэслэл

...

2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 36-д хийсэн хянан засварлалт

- ДҮ17. УСНББОУС3 нь 2016 оны 12-р сард НББОУС3-өөс гаргасан, 2014-2016 оны хооронд СТОУС-үүдэд Хийсэн Жилийн Сайжруулалтууд-д тусгагдсан НББОУС 28, Хараат Компани ба Хамтарсан Үйлдвэр дэх Хөрөнгө Оруулалт-ын хянан засварлалт, түүнчлэн Дүгнэлтийн Үндэслэлд заасан, НББОУС3-ийн ийм нэмэлт өөрчлөлт хийх болсон шалтгаан үндэслэлийг нягталж үзсэн. Байгууллага нь өмчийн арга хэрэглэх эсвэл хараат байгууллага болон хамтарсан үйлдвэр дэх

² Байгууллага нь УСНББОУС 41-ийг хараахан мөрдөөгүй байгаа тохиолдолд УСНББОУС 29, Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн Зөвшөөрөлт ба Хэмжилт-ийн дагуу хэмжинэ.

2018 ОНЫ УСНББОУС-ЫН САЙЖРУУЛАЛТУУД

хөрөнгө оруулалт нэг бүрийн хувьд тухайн хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр хэмжих аль нэг сонголт хийх боломжтой гэдгийг эдгээр нэмэлт өөрчлөлтүүдээр тодорхой болгож өгсөн.

ДҮ18. Жижиг дунд үйлдвэрт хөрөнгө оруулагч байгууллагууд, хамтын сан, хамтын итгэлцлийн сан болон тэдгээртэй адилтгах байгууллагууд, үүн дотроо хөрөнгө оруулалттай хосолсон даатгалын сан гэх мэт байгууллагын шууд эсвэл шууд бусаар эзэмшдэг хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтын хувьд эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг үл мөрдөх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэдэгтэй УСНББОУСЗ нь ерөнхийдөө санал нэгдсэн.

ДҮ19. Гэвч өөрөө хөрөнгө оруулалтын байгууллага болох хараат байгууллага буюу хамтарсан үйлдвэр дэх хувь оролцооны хувьд УСНББОУСЗ нь бодит үнэ цэнийн хэмжилтийг заавал мөрдөхөөр УСНББОУС 36-д (НББОУС 28-д заасан, арга хандлагын эсрэг аргыг) аль хэдийн тодорхойлсон. Иймээс УСНББОУСЗ нь НББОУС 28-д оруулсан нэмэлт өөрчлөлт буюу 36А параграфыг мөрдөхөөр сонгож аваагүй.

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг II-5а

УСНББОУС 4, Гадаад Валютын Ханиийн Өөрчлөлтийн Үр Нөлөө-нд оруулсан нэмэлт өөрчлөлт

70А, 70Б, 71Д параграф болон Хавсралт А (А1-А9-р параграф)-г шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур зурсан.

...

Шилжилтийн нөхцөл

...

Гадаад Валютын Ажил Гүйлгээ ба Урьдчилгаа Төлбөр (2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар оруулсан нэмэлт өөрчлөлт)

70А. Анх мөрдөх үед байгууллага нь Хавсралт А-гийн шаардлагуудыг дараах хоёр хувилбарын аль нэгээр мөрдөнө:

(а) УСНББОУС 3, Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Нягтлан Бодох Бүртгэлийн Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа-г буцаах горимоор мөрдсөнөөр; эсвэл

(б) Доорх өдрөөр буюу түүнээс хойш анх хүлээн зөвшөөрсөн, Хавсралт А-гийн цар хүрээнд хамаарах бүх хөрөнгө, зардал, орлогын хувьд гүйцээх горимоор:

(i) Хавсралт А-г уг байгууллага анх мөрдсөн тухайн тайлант үеийн эхэн; эсвэл

(ii) Хавсралт А-г уг байгууллага анх мөрдсөн тухайн тайлант үеийн санхүүгийн тайланд зэрэгцүүлэгдэх мэдээлэл байдлаар толилуулсан өмнөх тайлант үеийн эхэн.

70Б. Анх мөрдөх үедээ 70А(б) параграфыг мөрдөж буй байгууллага нь 70А(б)(i) эсвэл (ii) параграфт дурдсан, тайлант үеийн эхэнд болон түүнээс хойш анх хүлээн зөвшөөрсөн хөрөнгө, зардал, орлогын хувьд Хавсралт А-г мөрдөнө. Энэ нь уг өдрөөс өмнөх урьдчилгаа төлбөрөөс үүссэн мөнгөн зүйлсийн бус хөрөнгө буюу мөнгөн зүйлсийн бус өр төлбөрийг тухайн байгууллага хүлээн зөвшөөрсөн тайлант үе юм.

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

71Д. 2018 оны 10 дугаар сард гаргасан, 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 70А, 70Б, болон Хавсралт А (А1-А9-р параграф)-г шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

...

Хавсралт А

Гадаад Валютын Ажил Гүйлгээ ба Урьдчилгаа Төлбөр

Энэхүү Хавсралт нь УСНББОУС 4-ийн салшгүй нэг хэсэг юм.

Танилцуулга

А1. Анх хүлээн зөвшөөрөх үедээ байгууллага нь гадаад валютаар гарсан ажил гүйлгээний дүнг тухайн ажил гүйлгээний өдрөөрх бүртгэлийн валют ба гадаад валютын хоорондох спот ханшаар

(арилжааны ханшаар) үржүүлж, өөрийн бүртгэлийн валютаар бүртгэхийг УСНББОУС 4, Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө-ний 24-р параграфтаар шаардсан байдаг. Ажил гүйлгээний өдөр гэдэг нь тухайн ажил гүйлгээ УСНББОУС-ын дагуу хүлээн зөвшөөрөлтийн шалгуурыг анх хангасан өдөр юм гэж УСНББОУС 4-ийн 25-р параграфт заасан.

- A2. Байгууллага нь төлбөрийг гадаад валютаар урьдчилж төлсөн эсвэл хүлээн авсан тохиолдолд холбогдох хөрөнгө, зардал, орлогын хүлээн зөвшөөрөлтөөс өмнө, мөнгөн зүйлийн бус хөрөнгө буюу мөнгөн зүйлийн бус өр төлбөрийг ерөнхийдөө хүлээн зөвшөөрдөг. Холбогдох хөрөнгө, зардал, орлого (буюу түүний хэсэг) нь хамаарах УСНББОУС-ыг мөрдсөнөөр хүлээн зөвшөөрсөн дүн бөгөөд энэ нь уг урьдчилгаа төлбөрөөс үүссэн мөнгөн зүйлийн бус хөрөнгө буюу мөнгөн зүйлийн бус өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлтөнд хүргэдэг.
- A3. Байгууллага нь төлбөрийг гадаад валютаар урьдчилж хүлээн авсан эсвэл төлсөн тохиолдолд холбогдох хөрөнгө, зардал, орлогын анхны хүлээн зөвшөөрөлтөнд ашиглах ханшийг тодорхойлох зорилгоор тухайн ажил гүйлгээний өдрийг энэ Хавсралтанд тодруулж өгсөн.

Цар хүрээ

- A4. Холбогдох хөрөнгө, зардал, орлогыг (буюу түүний хэсгийг) хүлээн зөвшөөрөхөөс өмнө, байгууллага нь урьдчилж төлсөн зардал буюу урьдчилж төлсөн орлогоос үүссэн, мөнгөн зүйлийн бус хөрөнгө буюу мөнгөн зүйлийн бус өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг тохиолдолд гадаад валютын ажил гүйлгээнд (буюу түүний хэсэгт) энэ Хавсралтыг мөрдөнө.
- A5. Анх хүлээн зөвшөөрөх үедээ байгууллага нь холбогдох хөрөнгө, зардал, орлогыг дараах байдлаар хэмждэг тохиолдолд энэ Хавсралтыг мөрдөхгүй:
- (a) Бодит үнэ цэнээр; эсвэл
- (b) Урьдчилгаа төлбөрөөс үүссэн, мөнгөн зүйлийн бус хөрөнгө буюу мөнгөн зүйлийн бус өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлтийн өдрөөс өөр өдөр төлсөн эсвэл хүлээн авсан төлбөрийн бодит үнэ цэнээр (жишээлбэл; УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-ийг мөрдсөнөөр гүүдвиллийг хэмжих).
- A6. Байгууллага нь дараах зүйлсэд энэ Хавсралтыг мөрдөх шаардлагагүй юм:
- (a) Орлогын татвар; эсвэл
- (b) Гаргасан даатгалын гэрээ (үүн дотроо, давхар даатгалын гэрээ) эсвэл эзэмшиж буй давхар даатгалын гэрээ.

Гадаад валютын ажил гүйлгээ ба урьдчилгаа төлбөрт УСНББОУС 4-ийг мөрдөх

- A7. Гадаад валютаар урьдчилж төлсөн эсвэл хүлээн авсан төлбөрөөс үүссэн, мөнгөн зүйлийн бус хөрөнгө буюу мөнгөн зүйлийн бус өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлтийн хувьд холбогдох хөрөнгө, зардал, орлогыг (буюу түүний хэсгийг) анх хүлээн зөвшөөрөхөд ашиглах ханшийг тодорхойлох зорилгын хувьд тухайн ажил гүйлгээний өдрийг хэрхэн тогтоохыг энэ Хавсралтанд авч үзсэн.
- A8. УСНББОУС 4-ийн 24-25-р параграфыг мөрдөх үед холбогдох хөрөнгө, зардал, орлогыг (буюу түүний хэсгийг) анх хүлээн зөвшөөрөхөд ашиглах ханшийг тодорхойлох зорилгын хувьд тухайн ажил гүйлгээний өдөр нь урьдчилж төлсөн эсвэл хүлээн авсан төлбөрөөс үүссэн, мөнгөн зүйлийн бус хөрөнгө буюу мөнгөн зүйлийн бус өр төлбөрийг уг байгууллага анх хүлээн зөвшөөрөх өдөр юм.
- A9. Хэрэв урьдчилж төлсөн эсвэл хүлээн авсан олон төлбөр байвал байгууллага нь урьдчилж төлсөн эсвэл хүлээн авсан төлбөр нэг бүрийн хувьд ажил гүйлгээний өдрийг тодорхойлно.

Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 4-ийг дагалдах боловч түүний салишгүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 4-д хийсэн хянан засварлалт

ДҮ7. УСНББОУС3 нь 2016 оны 12-р сард НББОУС3-өөс гаргасан, СТОУТХ-ны Тайлбар 22, Гадаад Валютын Ажил Гүйлгээ ба Урьдчилгаа Төлбөр-ийн шаардлагууд, түүнчлэн Дүгнэлтийн Үндэслэлд заасан, СТОУС-ын Тайлбарын Хорооны ийм зөвшилцөлд хүрэх болсон шалтгаан үндэслэлийг нягталж үзсэн. Эдгээр шаардлагуудыг УСНББОУС 4-т тусган оруулахгүй гэсэн улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэдэгтэй УСНББОУС3 нь ерөнхийдөө санал нэгдсэн.

Үлгэрчилсэн жишээ

Энэхүү үлгэрчилсэн жишээ нь УСНББОУС 4-ийг дагалдах боловч түүний саллигүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

Гадаад Валютын Ажил Гүйлгээ ба Урьдчилгаа Төлбөр

Эдгээр үлгэрчилсэн жишээний хувьд гадаад валютын дүнг 'гадаад валют' (ГВ), бүртгэлийн валютыг 'орон нутгийн валют' (ОНВ) гэж гэмдэглэсэн.

ҮЖ1. Хамаарах УСНББОУС-ыг мөрдсөнөөр холбогдох хөрөнгө, зардал, орлогыг (буюу түүний хэсгийг) хүлээн зөвшөөрөхийн өмнө, байгууллага нь гадаад валютын урьдчилгаа төлбөрөөс үүссэн мөнгөн зүйлийн бус хөрөнгө буюу мөнгөн зүйлийн бус өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх үед тухайн ажил гүйлгээний өдрийг хэрхэн тодорхойлохыг үлгэрчлэн харуулахад эдгээр жишээний зорилго оршино.

Жишээ 1–Үндсэн хөрөнгийн нэг зүйлийг худалдан авах нэг удаагийн урьдчилгаа төлбөр

ҮЖ2. А байгууллага нь өөрийн үйл ажиллагаанд ашиглах автомашин худалдан авахын тулд 20X1 оны 3-р сарын 01-нд бэлтгэн нийлүүлэгчтэй гэрээ байгуулсан. Гэрээний нөхцлийн дагуу 20X1 оны 4-р сарын 01-нд А байгууллага нь худалдан авалтын тогтмол үнэ болох 1,000 ГВ-ыг бэлтгэн нийлүүлэгчид төлсөн. 20X1 оны 4-р сарын 15-нд А байгууллага нь автомашиныг биетээр хүлээн авсан.

ҮЖ3. А байгууллага нь бүртгэлийн валют ба гадаад валютын хоорондох 20X1 оны 4-р сарын 01-ний өдрийн спот ханшаар уг 1,000 ГВ-ыг хөрвүүлснээр тэрхүү мөнгөн зүйлийн бус хөрөнгийг өөрийн бүртгэлийн валютаар анх хүлээн зөвшөөрнө. УСНББОУС 4, Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө-ний 27(б) параграфт заасны дагуу А байгууллага нь уг мөнгөн зүйлийн бус хөрөнгийн хөрвүүлэн бүртгэсэн дүнг өөрчлөн шинэчлэхгүй.

ҮЖ4. 20X1 оны 4-р сарын 15-нд А байгууллага нь автомашиныг биетээр хүлээн авсан. А байгууллага нь уг мөнгөн зүйлийн бус хөрөнгийг үл хүлээн зөвшөөрч, УСНББОУС 17, Үндсэн Хөрөнгө-ийн дагуу тэрхүү автомашиныг үндсэн хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө. Автомашиныг анх хүлээн зөвшөөрөх үед А байгууллага нь тухайн ажил гүйлгээний өдрийн, өөрөөр хэлбэл 20X1 оны 4-р сарын 01-ний өдрийн (мөнгөн зүйлийн бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсөн өдрийн) ханшийг ашиглан уг автомашины өртгийг хүлээн зөвшөөрнө.

Жишээ 2–Хугацааны ганцхан цэг дээр хүлээн зөвшөөрөх орлогын олон удаагийн мөнгөн орлого

ҮЖ5. Б байгууллага нь 20X2 оны 9-р сарын 01-нд барааг нийлүүлж өгөх гэрээг худалдан авагчтай 20X2 оны 6-р сарын 01-нд байгуулсан. Гэрээний нийт тогтмол үнэ нь 100 ГВ, үүнээс 40 ГВ-ыг 20X2 оны 8-р сарын 01-нд төлөх ёстой бөгөөд мөн өдөр хүлээн авсан. Үлдсэн дүнг 20X2 оны 9-р сарын 30-нд хүлээн авна.

ҮЖ6. Б байгууллага нь бүртгэлийн валют ба гадаад валютын хоорондох 20X2 оны 8-р сарын 01-ний өдрийн спот ханшаар уг 40 ГВ-ыг хөрвүүлснээр тэрхүү гэрээний мөнгөн зүйлийн бус өр төлбөрийг өөрийн бүртгэлийн валютаар анх хүлээн зөвшөөрнө. УСНББОУС 4-ийн 27(б) параграфт заасны дагуу Б байгууллага нь уг мөнгөн зүйлийн бус өр төлбөрийн хөрвүүлэн бүртгэсэн дүнг өөрчлөн шинэчлэхгүй.

2018 ОНЫ УСНББОУС-ЫН САЙЖРУУЛАЛТУУД

ҮЖ7. УСНББОУС 9, Арилжааны Ажил Гүйлгээний Орлого-ын 28-р параграфт заасны дагуу Б байгууллага нь 20Х2 оны 9-р сарын 01-нд, өөрөөр хэлбэл тухайн барааг худалдан авагчид шилжүүлсэн өдөр орлогыг хүлээн зөвшөөрнө.

ҮЖ8. 40 ГВ-ын урьдчилгаа төлбөртэй холбоотой орлогын хувьд ажил гүйлгээний өдөр нь 20Х2 оны 8-р сарын 01 гэж Б байгууллага тодорхойлсон. Орлогын үлдэх хэсгийн хувьд тухайн ажил гүйлгээний өдөр нь 20Х2 оны 9-р сарын 01 гэж Б байгууллага нь УСНББОУС 4-ийн 25-р параграфын дагуу тодорхойлсон.

ҮЖ9. 20Х2 оны 9-р сарын 01-нд Б байгууллага нь:

(а) Гэрээний 40 ГВ-ын өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрч, 20Х2 оны 8-р сарын 01-ний ханшийг ашиглан орлогыг хүлээн зөвшөөрнө; ба

(б) Тухайн өдрийн (20Х2 оны 9-р сарын 01-ний) ханшийг ашиглан 60 ГВ-ын орлого болон холбогдох авлагыг хүлээн зөвшөөрнө.

ҮЖ10. 20Х2 оны 9-р сарын 01-нд хүлээн зөвшөөрсөн 60 ГВ-ын авлага нь мөнгөн зүйл юм. Б байгууллага нь авлага барагдах хүртэл уг авлагын хөрвүүлсэн дүнг шинэчлэн өөрчилж байна.

Жишээ 3–Цаг хугацааны туршид үйлчилгээг худалдан авах олон удаагийн мөнгөн төлбөр

ҮЖ11. В байгууллага нь үйлчилгээ хүлээн авах гэрээг 20Х3 оны 5-р сарын 01-нд нийлүүлэгчтэй байгуулсан. Тус нийлүүлэгч нь В байгууллагад үйлчилгээг 20Х3 оны 7-р сарын 01-нээс 20Х3 оны 12-р сарын 31 хүртэлх хугацааны туршид тэнцүү хэмжээгээр үзүүлнэ. Гэрээний дагуу В байгууллага нь уг нийлүүлэгчид 20Х3 оны 6-р сарын 15-нд 200 ГВ, 20Х3 оны 12-р сарын 31-нд 400 ГВ төлөх ёстой. Энэ гэрээний хувьд 20Х3 оны 6-р сарын 15-ны өдрийн 200 ГВ-ын төлбөр нь 20Х3 оны 7-р сарын 01-нээс 20Х3 оны 8-р сарын 31-ний хооронд хүлээн авах үйлчилгээнд хамаарна, харин 20Х3 оны 12-р сарын 31-ний өдрийн 400 ГВ-ын төлбөр нь 20Х3 оны 9-р сарын 01-нээс 20Х3 оны 12-р сарын 31-ний хооронд хүлээн авах үйлчилгээнд хамаарна гэж В байгууллага тодорхойлсон.

ҮЖ12. В байгууллага нь бүртгэлийн валют ба гадаад валютын хоорондох 20Х3 оны 6-р сарын 15-ны өдрийн спот ханшаар уг 200 ГВ-ыг хөрвүүлснээр тэрхүү мөнгөн зүйлийн бус хөрөнгийг өөрийн бүртгэлийн валютаар анх хүлээн зөвшөөрнө.

ҮЖ13. 20Х3 оны 7-р сарын 01-нээс 20Х3 оны 8-р сарын 31 хүртэлх тайлант үед В байгууллага нь тухайн нийлүүлэгчээс үйлчилгээг хүлээн авснаар уг мөнгөн зүйлийн бус хөрөнгийг үл хүлээн зөвшөөрч, 200 ГВ-ын зардлыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Тэрхүү 200 ГВ-ын урьдчилгаа төлбөртэй холбоотой зардлын хувьд ажил гүйлгээний өдөр нь 20Х3 оны 6-р сарын 15 (мөнгөн зүйлийн бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсөн өдөр) байна гэж В байгууллага тодорхойлсон.

ҮЖ14. 20Х3 оны 9-р сарын 01-нээс 20Х3 оны 12-р сарын 31 хүртэлх тайлант үед В байгууллага нь тухайн нийлүүлэгчээс үйлчилгээг хүлээн авснаар зардлыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Зарчмын 20Х3 оны 9-р сарын 01-нээс 20Х3 оны 12-р сарын 31 хүртэлх тайлант үеийн өдөр бүр нь тухайн ажил гүйлгээний өдөр байна. Гэвч ханш нь мэдэгдэхүйц хэмжээгээр хэлбэлзэхгүй бол В байгууллага нь УСНББОУС 4-ийн 25-р параграфтаар хүлээн зөвшөөрсөнчлөн, бодит ханштай ойролцоо ханшийг ашиглаж болох юм. Ийм тохиолдолд В байгууллага нь 20Х3 оны 9-р сарын 01-нээс 20Х3 оны 12-р сарын 31 хүртэлх тайлант үеийн хувьд тухайлбал, сар тутмын дундаж ханшийг ашигласнаар сар бүрийн 100 ГВ (400 ГВ:4)-ын зардлыг өөрийн бүртгэлийн валютанд хөрвүүлж болно.

ҮЖ15. 20Х3 оны 9-р сарын 01-нээс 20Х3 оны 12-р сарын 31 хүртэлх тайлант үед В байгууллага нь зардлыг хүлээн зөвшөөрснөөр тухайн нийлүүлэгчид төлбөр төлөх өөрийн үүргийн хувьд холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Өр төлбөр нь мөнгөн зүйл юм. В байгууллага нь өр төлбөрийг барагдуулах хүртэл түүний уг хөрвүүлсэн дүнг өөрчлөн шинэчилнэ.

Жишээ 4–Хугацааны олон цэг дээр хүлээн зөвшөөрөх орлогын олон удаагийн мөнгөн орлого

2018 ОНЫ УСНББОУС-ЫН САЙЖРУУЛАЛТУУД

ҮЖ16. Г байгууллага нь хоёр ширхэг барааг нийлүүлж өгөх гэрээг худалдан авагчтай 20X4 оны 01-р сарын 01-нд байгуулсан. Г байгууллага нь нэг барааг 20X4 оны 3-р сарын 01-нд, нөгөө барааг 20X4 оны 6-р сарын 01-нд шилжүүлэн өгсөн. Гэрээний дагуу, худалдан авагч нь худалдан авалтын үнэ болох тогтмол 1,000 ГВ-ыг төлөх шаардлагатай ба үүнээс 200 ГВ-ыг 20X4 оны 01-р сарын 31-нд урьдчилж төлөх ёстой бөгөөд мөн өдөр хүлээн авсан. Үлдсэн дүнг 20X4 оны 6-р сарын 01-нд төлөх ёстой ба уг өдөр үүнийг хүлээн авсан.

ҮЖ17. Дараах мэдээлэл өгөгдсөн:

- (a) Эхний барааны үнэ 450 ГВ, хоёр дахь барааны үнэ 550 ГВ байсан.
- (б) Энэ гэрээний хувьд 20X4 оны 01-р сарын 31-нд хүлээн авсан 200 ГВ-ын төлбөр нь 20X4 оны 3-р сарын 01-нд шилжүүлэн өгсөн эхний бараанд хамаарна гэж Г байгууллага тодорхойлсон. Худалдан авагчид уг барааг шилжүүлэн өгснөөр Г байгууллага нь 250 ГВ-ын үлдэгдэл төлбөрийг авах нөхцөлт бус эрхтэй болно.

ҮЖ18. Спот ханш дараах байдалтай байв:

Огноо	ГВ ба ОНВ-ын хоорондох спот ханш
20X4 оны 01-р сарын 31	1:1.5
20X4 оны 3-р сарын 01	1:1.7
20X4 оны 6-р сарын 01	1:1.9

ҮЖ19. Г байгууллага нь тухайн гэрээний гадаад валютын төлөв байдлыг хэрхэн тайлагнахыг дараах журналын бичлгээр үлгэрчлэн харуулав:

- (a) Г байгууллага нь 20X4 оны 01-р сарын 31-нд 200 ГВ-ын урьдчилгаа төлбөрийг хүлээн авч, 20X4 оны 01-р сарын 01-ний ханшийг ашиглан түүнийг өөрийн бүртгэлийн валютанд хөрвүүлсэн.

<u>Дебит Мөнгө (200 ГВ)</u>	<u>300 ОНВ</u>
<u>Кредит Гэрээний өр төлбөр (200 ГВ)</u>	<u>300 ОНВ</u>

- (б) УСНББОУС 4-ийн 27(б) параграфт заасны дагуу Г байгууллага нь уг гэрээний мөнгөн зүйлийн бус өр төлбөрийн хөрвүүлэн бүртгэсэн дүнг өөрчлөн шинэчлэхгүй.

- (в) Г байгууллага нь 450 ГВ-ын үнэ бүхий эхний барааг 20X4 оны 3-р сарын 01-нд шилжүүлэн өгсөн. Г байгууллага нь уг гэрээний өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрч, 300 ОНВ-ын орлогыг хүлээн зөвшөөрнө. Г байгууллага нь эхний бараанд хамаарах 250 ГВ-ын үлдсэн орлого болон харгалзах авлагыг хүлээн зөвшөөрнө. Үлдсэн 250 ГВ-ын орлогыг анх хүлээн зөвшөөрсөн өдрийн, өөрөөр хэлбэл 20X4 оны 3-р сарын 01-ний өдрийн ханшаар энэхүү орлого болон авлагын аль алиныг хөрвүүлнэ.

<u>Дебит Гэрээний өр төлбөр (200 ГВ)</u>	<u>300 ОНВ</u>
<u>Дебит Авлага (250 ГВ)</u>	<u>425 ОНВ</u>
<u>Кредит Орлого (450 ГВ)</u>	<u>725 ОНВ</u>

- (г) 250 ГВ-ын авлага нь мөнгөн зүйл юм. Г байгууллага нь авлага барагдах (20X4 оны 6-р сарын 01) хүртэл уг авлагын хөрвүүлсэн дүнг шинэчлэн өөрчилж байна. 20X4 оны 6-р сарын 01-нд 250 ГВ-ын авлага нь 475 ОНВ-тай тэнцүү байв. УСНББОУС 4-ийн 32-р параграфт заасанчлан, Г байгууллага нь 50 ОНВ-ын ханшийн олзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

<u>Дебит Авлага</u>	<u>50 ОНВ</u>
<u>Кредит Валютын ханшийн олз</u>	<u>50 ОНВ</u>

- (д) Г байгууллага нь 550 ГВ-ын үнэ бүхий хоёр дахь барааг 20X4 оны 6-р сарын 01-нд шилжүүлэн өгсөн. Г байгууллага нь тухайн ажил гүйлгээний өдрийн ханшийг ашигласнаар 550 ГВ-ын орлогыг хүлээн зөвшөөрнө. Ажил гүйлгээний өдөр гэдэг нь тухайн ажил гүйлгээний энэхүү хэсгийг Г байгууллага өөрийн санхүүгийн тайландаа анх хүлээн зөвшөөрсөн өдөр буюу нь 20X4 оны 6-р сарын 01 юм.

2018 ОНЫ УСНББОУС-ЫН САЙЖРУУЛАЛТУУД

(e) Г байгууллага нь үлдсэн 800 ГВ-ын төлбөрийг 20Х4 оны 6-р сарын 01-нд мөн хүлээн авсан. Хүлээн авсан төлбөрийн 250 ГВ нь эхний барааны шилжүүлэлтээр үүссэн 250 ГВ-ын авлагын барагдуулалт юм. Г байгууллага нь мөнгөн дүнг 20Х4 оны 6-р сарын 01-ний өдрийн ханшаар хөрвүүлсэн.

Дебит Мөнгө (800 ГВ)

1,520 ОНВ

Дебит Авлага (250 ГВ)

475 ОНВ

Кредит Орлого (550 ГВ)

1,045 ОНВ

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг II-56

УСНББОУС 33, Аккруэл Суурьт Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС)-ыг Анх Удаа Мөрдөх-д оруулсан нэмэлт өөрчлөлт

85A, 154E параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур зурсан.

...

Мөрдөх хугацаанд үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөхгүй чөлөөлөх нөхцлүүд

...

УСНББОУС 4, Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө

...

85A. Агб о́ааа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс өмнө анх хүлээн зөвшөөрсөн ба УСНББОУС 4-ийн Хавсралт А-гийн цар хүрээнд хамаарах хөрөнгө, зардал, орлогын хувьд уг Хавсралт А-г даган мөрдөх албагүй юм.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

154E. 2018 оны 10 дугаар сард гаргасан, 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 85A параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь уг нэмэлт өөрчлөлтийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед энэхүү нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийх бөгөөд тэр үеэс эхлэн 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-д тусгагдсан УСНББОУС 4-ийн нэмэлт өөрчлөлтүүдийг даган мөрдөнө.

...

Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 33-ыг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 33-т хийсэн хянан засварлалт

ДҮ120. УСНББОУС3 нь 2016 оны 12-р сард НББОУС3-өөс гаргасан, СТОУТХ-ны Тайлбар 22, Гадаад Валютын Ажил Гүйлгээ ба Урьдчилгаа Төлбөр-ийн шаардлагууд, түүнчлэн Дүгнэлтийн Үндэслэлд заасан, СТОУС-ын Тайлбарын Хорооны ийм зөвшилцөлд хүрэх болсон шалтгаан үндэслэлийг нягталж үзсэн. Эдгээр шаардлагуудыг УСНББОУС 4, Гадаад Валютын Ханшийн Өөрчлөлтийн Үр Нөлөө-нд тусган оруулахгүй гэсэн улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэдэгтэй УСНББОУС3 нь ерөнхийдөө санал нэгдсэн. Иймээс УСНББОУС3 нь СТОУТХ-ны Тайлбар 22-ын шаардлагуудыг УСНББОУС 4-ийн Хавсралт А-д тусган оруулахыг зөвшөөрсөн. Хавсралт А-гийн шаардлагуудыг байгууллагууд нь гүйцээх горимоор мөрдөхийг зөвшөөрнө гэдгээ УСНББОУС3 мэдэгдсэн бөгөөд иймээс анх удаа мөрдөж буй байгууллага нь УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс өмнө анх хүлээн зөвшөөрсөн ба УСНББОУС 4-ийн Хавсралт А-гийн цар хүрээнд хамаарах хөрөнгө, зардал, орлогын хувьд эдгээр шаардлагуудыг даган мөрдөх албагүй юм.

...

Хэрэгжүүлэх заавар удирдамж

...

УСНББОУС 33, Аккруэл Суурьт УСНББОУС-ыг Анх Удаа Мөрдөх-д заасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд ба заалтуудын товчоо

ХЗУ91. Аккруэл суурьт бусад УСНББОУС-д тусгасан, шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд ба заалтуудыг дараах схемд товчоолон харуулав.

УСНББОУС	Олгосон шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд							
	Үгүй	Тийм						
	Төсөөлөн тооцсон өртөг	Хүлээн зөвшөөрөлтөөс 3 жилийн хугацаанд чөлөөлөх	Хэмжилтээс 3 жилийн хугацаанд чөлөөлөх	Хүлээн зөвшөөрөлт ба/буюу хэмжилтээс 3 жилийн хугацаанд чөлөөлөх	Тодруулгаас 3 жилийн хугацаанд чөлөөлөх	Ажил гүйлгээ, үлдэгдэл, орлого, зардлыг устгаж цэвэрлэх	Бусад	
... УСНББОУС 4, Гадаад Валютын Ханиийн Өөрчлөлтийн Үр Нөлөө							Хуримтлагдсан хөрвүүлэлтийн шаардлагыг мөрдөхөөс чөлөөлсөн УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс өмнө анх хүлээн зөвшөөрсөн зүйлсийн хувьд Хавсралт А-г даган мөрдөх албагүй юм	

...

Хавсралт

Аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, анх удаа мөрдөж буй байгууллага нь мөрдөх шаардлагатай ба/буюу мөрдөхөөр сонгож болох шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд ба заалтуудын хоорондох ялгаатай талууд

Шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд ба заалтуудыг уг анх удаа мөрдөж буй байгууллага нь энэхүү УСНББОУС-ын нөхцлүүдийн хүрээнд хэрхэн мөрдөх шаардлагатай ба аккруэл суурьт УСНББОУС-ыг мөрдсөн өдөр, анх удаа мөрдөж буй байгууллага нь мөрдөхөөр сонгож болох шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд ба заалтуудыг энэ Хавсралтад доор товчоолон харуулав.

Сонгож болох эдгээр шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд ба заалтууд нь УСНББОУС 33-ын 27-32-р параграфт тайлбарласанчлан, үнэн зөв толилуулга болон аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх уг анх удаа мөрдөж буй байгууллагын чадвар боломжид нөлөөлдөг тул үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцсэн гэж мэдэгдэх чадвар боломжид нөлөөлдөг эсвэл нөлөөлдөггүй шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцөл, заалтуудыг энэ Хавсралтад ялган тодорхойлсон.

Шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцөл буюу заалт	Мөрдөх шаардлагатай шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд буюу заалтууд	Мөрдөж эсвэл сонгож болох шилжилтийн үеийн чөлөөлөх нөхцлүүд буюу заалтууд	
	Үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөхгүй	Үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөхгүй	Үнэн зөв толилуулга ба аккруэл суурьт УСНББОУС-тай нийцэлтэнд нөлөөлөх
... УСНББОУС 4			

2018 ОНЫ УСНББОУС-ЫН САЙЖРУУЛАЛТУУД

<ul style="list-style-type: none"> УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөрх шилжилтийн үеийн хуримтлагдсан зөрүү 		<p>0</p>	
<ul style="list-style-type: none"> <u>УСНББОУС-ыг мөрдсөн өдрөөс өмнө анх хүлээн зөвшөөрсөн зүйлсийн хувьд Хавсралт А-г даган мөрдөх албагүй юм</u> 		<p>√</p>	

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг II-6

УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр-т оруулсан нэмэлт өөрчлөлт

42Д, МЗУ33ВА параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур зурсан.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

42Д. 2018 оны 10 дугаар сард гаргасан, 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар МЗУ33ВА параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан эхний жилийн санхүүгийн тайлангийн эхнээс буюу түүнээс хойш хамтын хяналтыг олж авсан ажил гүйлгээнд энэхүү нэмэлт өөрчлөлтийг мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед энэхүү нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

...

Мөрдөх заавар удирдамж

Энэ Хавсралт нь УСНББОУС 37-гийн саллигүй бүрэлдэхүүн хэсэг юм.

...

Хамтын хэлэлцээрийн оролцогч талуудын санхүүгийн тайлан (23-28-р параграф)

Хамтын үйл ажиллагаан дахь хувь оролцооны худалдан авалтын тайлагнал

...

МЗУ33ВА. Хамтын үйл ажиллагаанд оролцдог боловч хамтын хяналтгүй тал нь УСНББОУС 40-д тодорхойлсон үйл ажиллагааг бүрдүүлдэг тийм ажиллагаа бүхий хамтын үйл ажиллагааны хувьд хамтын хяналтыг олж авч болох юм. Ийм тохиолдолд уг хамтын үйл ажиллагаанд өмнө нь эзэмшиж байсан хувь оролцоог дахин хэмжихгүй.

...

Дүгнэлтийн Үндэслэл

...

2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 37-д хийсэн хянан засварлалт

ДҮ10. УСНББОУС3 нь 2017 оны 12-р сард НББОУС3-өөс гаргасан, 2015-2017 оны хооронд СТОУС®-уудад Хийсэн Жилийн Сайжруулалтууд-д тусгагдсан СТОУС 11, Хамтын Хэлэлцээр-ийн хянан засварлалт, түүнчлэн Дүгнэлтийн Үндэслэлд заасан, НББОУС3-ийн ийм нэмэлт өөрчлөлтүүд хийх болсон шалтгаан үндэслэлийг нягталж үзээд эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг үл мөрдөх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэдэгтэй ерөнхийдөө санал нэгдсэн.

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг II-7

УСНББОУС 40, Улсын Секторын Нэгдэл-д оруулсан нэмэлт өөрчлөлт

100А, 126Б параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур зурсан.

...

Худалдан авалтын тайлагналын арга

...

Үе шаттайгаар хийсэн худалдан авалт

...

100А. Хамтын хэлэлцээрийн оролцогч тал (УСНББОУС 37, Хамтын Хэлэлцээр-т тодорхойлсон) нь хамтын үйл ажиллагаа (УСНББОУС 37-д тодорхойлсон) болох тийм үйл ажиллагааны хяналтыг олж авсан бөгөөд тухайн худалдан авалтын өдрийн яг өмнө тэрхүү хамтын үйл ажиллагаатай холбоотой хөрөнгийн хувьд эрхтэй, өр төлбөрийн хувьд үүрэгтэй байсан бол уг ажил гүйлгээ нь үе шаттайгаар хийсэн худалдан авалт болно. Иймээс нэгтгэгч нь үе шаттайгаар хийсэн худалдан авалтын шаардлагуудыг мөрдөнө, үүн дотроо уг хамтын үйл ажиллагаанд өөрийн өмнө нь эзэмшиж байсан хувь оролцоог 100-р параграфт заасан арга маягийн дагуу дахин хэмжинэ. Үүний тулд нэгтгэгч нь тэрхүү хамтын үйл ажиллагаанд өөрийн өмнө нь эзэмшиж байсан хувь оролцоог бүхэлд нь дахин хэмжинэ.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

126Б. 2018 оны 10 дугаар сард гаргасан, 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 100А параграфыг шинээр нэмсэн, 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан эхний жилийн санхүүгийн тайлангийн эхэнд болон түүнээс хойш худалдан авалтын өдөр нь байх тийм улсын секторын нэгдлийн хувьд байгууллага нь энэхүү нэмэлт өөрчлөлтийг мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед энэхүү нэмэлт өөрчлөлтийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

...

Дүгнэлтийн Үндэслэл

...

2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 40-д хийсэн хянан засварлалт

ДҮ94. УСНББОУСЗ нь 2017 оны 12-р сард НББОУСЗ-өөс гаргасан, 2015-2017 оны хооронд СТОУС®-уудад Хийсэн Жилийн Сайжруулалтууд-д тусгагдсан СТОУС 3, Бизнесийн Нэгдэл-ийн хянан засварлалт, түүнчлэн Дүгнэлтийн Үндэслэлд заасан, НББОУСЗ-ийн ийм нэмэлт өөрчлөлтүүд хийх болсон шалтгаан үндэслэлийг нягталж үзсэн. УСНББОУС 40-д дурдсан, үе шаттайгаар хийсэн худалдан авалтын тайлагнал нь СТОУС 3-т заасантай ижил байсан тул УСНББОУСЗ нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг үл мөрдөх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэдэгтэй ерөнхийдөө санал нэгдсэн.

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг II-8

УСНББОУС 5, Зээлийн Өртөг-т оруулсан нэмэлт өөрчлөлт

25-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 41А, 42Г параграфыг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Зээлийн өртөг-Зөвшөөрөгдсөн сонголтот хандлага

...

Капиталжуулах боломжтой зээлийн өртөг

...

25. Мөнгө санг ерөнхий зориулалтаар зээлдэн авсан боловч шалгуур хангах хөрөнгийг олж авах зорилгоор тэрхүү мөнгө санг ашиглан зарцуулсан тохиолдолд тухайн хөрөнгөнд хийгдсэн зарлагын дүнг капиталжуулалтын хувь хэмжээгээр үржүүлснээр капиталжуулах боломжтой зээлийн өртгийн дүнг тодорхойлно. Капиталжуулалтын хувь хэмжээ нь ~~шалгуур хангах хөрөнгийг олж авах зорилгоор тусгайлан авсан зээлээс бусад~~, тухайн тайлант үеийн туршид төлөгдөөгүй байгаа уг байгууллагын бүх зээлд хамаарах зээлийн өртгийн жинэлсэн дундаж байна. Гэвч байгууллага нь хөрөнгийг түүний зориулалтын дагуу ашиглалт буюу борлуулалтад бэлтгэхэд шаардлагатай бараг бүх үйл ажиллагааг дуусгах хүртэл тухайн шалгуур хангах хөрөнгийг олж авах зорилгоор тусгайлан авсан зээлд хамаарах зээлийн өртгийг энэхүү тооцоололд оруулахгүй. Тайлант үеийн туршид капиталжуулах зээлийн өртгийн дүн нь тухайн тайлант үед гарсан зээлийн өртгийн нийт дүнгээс хэтрэх ёсгүй.

...

Шилжилтийн нөхцөл

...

41А. 2018 оны 10 дугаар сард гаргасан, 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 25-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулсан. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг анх мөрдсөн жилийн тайлант үеийн эхэнд буюу түүнээс хойш гарсан зээлийн өртөгт энэхүү нэмэлт өөрчлөлтийг мөрдөнө.

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

42Г. 2018 оны 10 дугаар сард гаргасан, 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 25-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 41А параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх тайлант үеүдийг хамарсан жилийн санхүүгийн тайланд мөрдөнө. Дүрдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнө эхлэх тайлант үед эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

...

Дүгнэлтийн Үндэслэл

...

2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 5-д хийсэн хянан засварлалт

ДҮ2. УСНББОУС3 нь 2017 оны 12-р сард НББОУС3-өөс гаргасан, 2015-2017 оны хооронд СТОУС®-уудад Хийсэн Жилийн Сайжруулалтууд–д тусгагдсан НББОУС 23, Зээлийн Өртөг-ийн хянан засварлалт, түүнчлэн Дүгнэлтийн Үндэслэлд заасан, НББОУС3-ийн ийм нэмэлт өөрчлөлтүүд хийх болсон шалтгаан үндэслэлийг нягталж үзсэн. Хэдийгээр УСНББОУС 5 ба НББОУС 23 хоорондоо өөр боловч УСНББОУС 5-д дурдсан, зөвшөөрөгдсөн сонголтот хандлагын тайлагнал нь НББОУС 23-т заасантай ижил гэдгийг УСНББОУС3 тэмдэглэсэн. Иймээс УСНББОУС3 нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг үл мөрдөх улсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг буцаах горимоор мөрдөх өртөг зардал нь түүний үр өгөөжөөс илүү гарч болох юм гэсэн НББОУС3-ийн байр суурьтай УСНББОУС3 нь санал нэг байсан. Иймээс байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг анх мөрдсөн өдөр буюу түүнээс хойш гарсан зээлийн өртөгт л үүнийг даган мөрддөг.

Нэмэлт өөрчлөлт: Хэсэг II-9

УСНББОУС 39, *Ажилтны Тэтгэмж*-д оруулсан нэмэлт өөрчлөлт

59, 101, 122, 125, 127, 128, 159-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 103А, 124А, 125А, 176А параграф, түүнчлэн 124А параграфын өмнөх гарчгийг шинээр нэмсэн. Шинэ текстийн доогуур, харин хасагдсан текстийн дундуур зурсан.

...

Ажил эрхлэлтийн дараах тэтгэмж-Тогтоосон шимтгэлийн хөтөлбөр

...

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

...

59. Тогтоосон тэтгэмжийн хөтөлбөрийг байгууллага бүртгэж, тайлагнахад дараах алхамуудыг гүйцэтгэнэ:

...

(в) Ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрөх дараах дүнгүүдийг тодорхойлох:

(i) Одоогийн үйлчилгээний зардал (72-76, 124А параграфыг үзнэ үү).

...

Өнгөрсөн үйлчилгээний зардал ба барагдуулалтаас үүссэн олз, гарз

101. ~~Өнгөрсөн үйлчилгээний зардал эсвэл барагдуулалтаас үүссэн олз, гарзыг тодорхойлохын өмнө үед~~ байгууллага нь ~~хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлт, цомхотгол буюу барагдуулалтаас өмнөх, тухайн хөтөлбөрийн дагуу санал болгож буй тэтгэмжүүдийг дараах зүйлсийг~~ тусган илэрхийлэх одоогийн актуар төсөөллүүдийг (үүн дотроо, одоогийн зах зээлийн хүүний түвшин ба одоогийн зах зээлийн бусад үнэ) болон хөтөлбөрийн хөрөнгийн одоогийн бодит үнэ цэнийг ашигласнаар уг тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийг дахин хэмжинэ.

(a) Хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлт, цомхотгол буюу барагдуулалтаас өмнөх, тухайн хөтөлбөр болон хөтөлбөрийн хөрөнгийн дагуу санал болгож буй тэтгэмжүүд; ба

(б) Хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлт, цомхотгол буюу барагдуулалтын дараах, тухайн хөтөлбөр болон хөтөлбөрийн хөрөнгийн дагуу санал болгож буй тэтгэмжүүд.

...

103А. Хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлт, цомхотгол буюу барагдуулалт хийсэн тохиолдолд байгууллага нь аливаа өнгөрсөн үйлчилгээний зардал эсвэл барагдуулалтаас үүссэн олз, гарзыг 101-103-р параграф болон 104-114-р параграфын дагуу хүлээн зөвшөөрч, хэмжинэ. Ингэхдээ байгууллага нь тухайн хөрөнгийн дээд хязгаарын үр нөлөөг харгалзан үзэхгүй. Байгууллага нь хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлт, цомхотгол буюу барагдуулалтын дараа, тухайн хөрөнгийн дээд хязгаарын үр нөлөөг тодорхойлж, тэрхүү үр нөлөөний өөрчлөлтийг 59(г) параграфын дагуу хүлээн зөвшөөрнө.

...

Тогтоосон тэтгэмжийн зардлын бүрэлдэхүүн хэсгүүд

122. **Өөр УСНББОУС нь тогтоосон тэтгэмжийн зардлын бүрэлдэхүүн хэсгүүдийг хөрөнгийн өртөгт оруулахыг шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага нь тогтоосон тэтгэмжийн зардлын бүрэлдэхүүн хэсгүүдийг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө:**

- (a) **Үйлчилгээний зардлыг ашиг, алдагдал (68–114, 124А параграфыг үзнэ үү);**

...

Одоогийн үйлчилгээний зардал

124А. Байгууллага нь тухайн тайлант жилийн эхэнд тодорхойлсон актуар төсөөллүүдийг ашигласнаар одоогийн үйлчилгээний зардлыг тодорхойлдог. Гэвч байгууллага нь тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийг 101-р параграфын дагуу дахин хэмждэг бол уг хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлт, цомхотгол буюу барагдуулалтын дараах, тухайн тайлант жилийн үлдсэн хугацаанд хамаарах одоогийн үйлчилгээний зардлыг тус байгууллага нь тэрхүү тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийг 101(б) параграфын дагуу дахин хэмжихдээ ашигласан, актуар төсөөллүүдэд үндэслэн тодорхойлно.

Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн цэвэр хүү

125. Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийг 85-р параграфт тусгайлан заасан дискаунтын түвшнээр үржүүлснээр байгууллага нь уг тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн цэвэр хүүг тодорхойлдог. Тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө) ба дискаунтын түвшний аль алиныг уг тайлант үеийн эхэнд тодорхойлох бөгөөд шимтгэл болон тэтгэмжийн төлбөрийн үр дүнд тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө) т тухайн тайлант үеийн туршид орох аливаа өөрчлөлтийг эдгээрт харгалзан үзнэ.

125А. Цэвэр хүүг 125-р параграфын дагуу тодорхойлохын тулд байгууллага нь тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө) болон тухайн тайлант жилийн эхэнд тодорхойлсон дискаунтын түвшинг ашиглана. Гэвч байгууллага нь тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийг 101-р параграфын дагуу дахин хэмждэг бол уг хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлт, цомхотгол буюу барагдуулалтын дараах, тухайн тайлант жилийн үлдсэн хугацаанд хамаарах одоогийн үйлчилгээний зардлыг тус байгууллага нь доорх зүйлсэд үндэслэн тодорхойлно:

(a) 101(б) параграфын дагуу тодорхойлсон, тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө); ба

(б) 101(б) параграфын дагуу уг тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийг дахин хэмжихдээ ашигласан, дискаунтын түвшин.

125А параграфыг мөрдөхдөө, байгууллага нь нийгмийн даатгалын шимтгэл эсвэл тэтгэмжийн төлбөрийн үр дүнд уг тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-нд тухайн тайлант үеийн туршид гарсан аливаа өөрчлөлтийг харгалзан үзнэ.

...

127. Хөтөлбөрийн хөрөнгийн хүүний орлого нь уг хөтөлбөрийн хөрөнгийн өгөөжийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тухайн хөтөлбөрийн хөрөнгийн бодит үнэ цэнийг 125А 85-р параграфт тусгайлан заасан дискаунтын түвшнээр үржүүлснээр үүнийг тодорхойлдог. Байгууллага нь хөтөлбөрийн хөрөнгийн бодит үнэ цэнийг Хөтөлбөрийн хөрөнгийн бодит үнэ цэнэ ба дискаунтын түвшний аль алиныг уг тухайн тайлант үеийн эхэнд тодорхойлно. тодорхойлох бөгөөд шимтгэл болон тэтгэмжийн төлбөрийн үр дүнд тухайн хөтөлбөрийн эзэмшиж буй хөрөнгөнд тайлант үеийн туршид орох аливаа өөрчлөлтийг эдгээрт харгалзан үзнэ. Гэвч байгууллага нь тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийг 101-р параграфын дагуу дахин хэмждэг бол уг хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлт, цомхотгол буюу барагдуулалтын дараах, тухайн тайлант жилийн үлдсэн хугацаанд хамаарах хүүний орлогыг тус байгууллага нь тэрхүү тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийг 101(б) параграфын дагуу дахин хэмжихдээ ашигласан хөтөлбөрийн хөрөнгөнд үндэслэн тодорхойлно. 127-р параграфыг мөрдөхдөө, байгууллага нь нийгмийн даатгалын шимтгэл эсвэл тэтгэмжийн төлбөрийн үр дүнд уг хөтөлбөрийн хөрөнгөнд тухайн тайлант үеийн туршид гарсан аливаа өөрчлөлтийг харгалзан үзнэ. Хөтөлбөрийн хөрөнгийн хүүний орлого ба хөтөлбөрийн хөрөнгийн өгөөжийн хоорондох зөрүүг уг тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн дахин хэмжилтийн дүнд тусган оруулна.

128. Хөрөнгийн дээд хязгаарын үр нөлөөний хүү нь хөрөнгийн дээд хязгаарын нийт өөрчлөлтийн нэг хэсэг бөгөөд уг хөрөнгийн дээд хязгаарын үр нөлөөг 125А 85-р параграфт тусгайлан заасан дискаунтын түвшнээр үржүүлснээр хүүг тодорхойлдог. ~~Хөрөнгийн дээд хязгаарын үр нөлөө ба дискаунтын түвшний аль алиныг уг тайлант үеийн эхэнд тодорхойлно. Байгууллага нь хөрөнгийн дээд хязгаарын үр нөлөөг тухайн тайлант үеийн эхэнд тодорхойлно. Гэвч байгууллага нь тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийг 101-р параграфын дагуу дахин хэмждэг бол уг хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлт, цомхотгол буюу барагдуулалтын дараах, тухайн тайлант жилийн үлдсэн хугацаанд хамаарах хөрөнгийн дээд хязгаарын үр нөлөөний хүүг тус байгууллага нь 103А параграфын дагуу тодорхойлсон, тэрхүү хөрөнгийн дээд хязгаарын үр нөлөөний аливаа өөрчлөлтийг харгалзан тодорхойлно. Хөрөнгийн дээд хязгаарын үр нөлөөний хүү Хүүний дүн ба хөрөнгийн дээд хязгаарын үр нөлөөний нийт өөрчлөлтийн хоорондох зөрүүг тухайн тогтоосон тэтгэмжийн цэвэр өр төлбөр (хөрөнгө)-ийн дахин хэмжилтийн дүнд тусган оруулдаг.~~

...

Ажилтны урт хугацааны бусад тэтгэмж

...

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

...

159. Өөр УСНББОУС нь дараах зүйлсийг хөрөнгийн өртөгт оруулахыг шаардсан буюу зөвшөөрснөөс бусад тохиолдолд байгууллага нь ажилтны урт хугацааны бусад тэтгэмжийн хувьд дараах зүйлсийг цэвэр дүнгээр нь ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө:

(а) Үйлчилгээний зардал (68-114, 124А параграфыг үзнэ үү);

...

Хүчин төгөлдөр болох хугацаа

...

176А. 2018 оны 10 дугаар сард гаргасан, 2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-аар 59, 101, 122, 125, 127, 128, 159-р параграфт нэмэлт өөрчлөлт оруулж, 103А, 124А, 125А параграфыг шинээр нэмсэн. Байгууллага нь 2019 оны 01 дүгээр сарын 01-нд буюу түүнээс хойш эхлэх анхны жилийн тайлант үеийн эхэнд буюу түүний дараа гарч тохиолдсон хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлт, цомхотгол буюу барагдуулалтын хувьд эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг мөрдөнө. Дурдсан хугацаанаас өмнө мөрдөхийг зөвшөөрнө. Хэрэв байгууллага нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийг дээрх дурдсан хугацаанаас өмнө мөрдсөн бол энэ тухай тодруулга хийнэ.

...

Дүгнэлтийн Үндэслэл

Энэхүү Дүгнэлтийн Үндэслэл нь УСНББОУС 39-ийг дагалдах боловч түүний салиггүй бүрэлдэхүүн хэсэг биш юм.

...

2018 оны УСНББОУС-ын Сайжруулалтууд-ын үр дүнд УСНББОУС 39-д хийсэн хянан засварлалт

ДҮ23. УСНББОУС3 нь 2018 оны 02-р сард НББОУС3-өөс гаргасан, Хөтөлбөрийн Нэмэлт Өөрчлөлт, Цомхотгол буюу Барагдуулалт (НББОУС 19-ийн Нэмэлт өөрчлөлт)-д тусгагдсан НББОУС 19, Ажилтны Тэтгэмж-ийн хянан засварлалт, түүнчлэн Дүгнэлтийн Үндэслэлд заасан, НББОУС3-ийн ийм нэмэлт өөрчлөлтүүд хийх болсон шалтгаан үндэслэлийг нягталж үзсэн. УСНББОУС3 нь эдгээр

2018 ОНЫ УСНББОУС-ЫН САЙЖРУУЛАЛТУУД

нэмэлт өөрчлөлтүүдийг үл мөрдөх үлсын секторын тусгай учир шалтгаан байхгүй гэдэгтэй ерөнхийдөө санал нэгдсэн.

ЗОХИОГЧИЙН ЭРХ, ХУДАЛДААНЫ ТЭМДЭГ, ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Саналын Төсөл, Зөвлөлдөх Баримт Бичиг, Санал Болгосон Практик Удирдамж болон УСНББОУСЗ-ийн бусад хэвлэлүүдийг ДНБХ-оос хэвлэн гаргасан бөгөөд түүний зохиогчийн эрхэд хамаарна.

Энэхүү хэвлэлд тусгагдсан материалуудад итгэл үзүүлэн үйлдэл хийсэн эсвэл үйлдлээ больсоны улмаас хэн нэгэнд хохирол учирсан тохиолдолд хохирол нь хайнга байдал буюу бусад шалтгаанаар үүссэн эсэхээс үл хамааран УСНББОУСЗ болон ДНБХ нь уг хохирлын хувьд хариуцлага хүлээхгүй болно.

‘International Public Sector Accounting Standards Board’ (Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл), ‘International Public Sector Accounting Standards’ (Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт), ‘Recommended Practice Guidelines’ (Санал Болгосон Практик Удирдамж), ‘International Federation of Accountants’ (Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо), ‘IPSASB’ (УСНББОУСЗ), ‘IPSAS’ (УСНББОУС), ‘RPG’ (СБПУ), ‘IFAC’ (ДНБХ), ‘IPSASB’ гэсэн лого, ‘IFAC’ гэсэн лого нь АНУ болон бусад улс орнууд дахь ДНБХ-ны худалдааны тэмдэг буюу бүртгэгдсэн худалдааны тэмдэг ба үйлчилгээний тэмдэг юм.

Зохиогчийн эрх © 2018 оны 10 дугаар сар, Дэлхийн Нягтлан Бодогчдын Холбоо (ДНБХ). Бүх эрх хамгаалагдсан. Энэхүү баримт бичгийг хувиан олшруулах, хадгалах, шилжүүлэх буюу бусад адилтгах байдлаар ашиглахын тулд ДНБХ-ноос бичгэн зөвшөөрөл авах шаардлагатай. permission@ifac.org хаягаар хандана уу.

ДНБХ-ноос хэвлэв





**Улсын Секторын Нягтлан
Бодох Бүртгэлийн Олон
Улсын Стандартын Зөвлөл®**

529 тавдугаар өргөн чөлөө,
Нью Йорк, Нью Йорк 10017
Утас: + 1 (212) 286-9344
Факс: + 1 (212) 286-9570
www.ipsasb.org